

САЙН ДУРЫНХАН НИЙГМИЙН ХӨГЖИЛД





Сайн дурынхан нийгмийн хөгжилд гарын авлага

Улаанбаатар хот
2007



Монголын Эмэгтэйчүүдийн Сан

Сайн дурын үндсэн дээр нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулахыг хүсч буй хэн бүхэнд зориулсан энэхүү гарын авлагыг бид өмнө нь МННХ Соросын сангийн дэмжлэгтэйгээр 500 хувь хэвлэн гаргасан билээ.

Уг гарын авлагыг олны хүртээл болгох хэрэгцээ шаардлага, мөн иргэд байгууллагаас ирсэн хүсэлтийг үндэслэн дахин 1000 хувийг НҮБ-ын Сайн Дурын Байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэвлэсэн бөгөөд одоо VSO сайн дурын байгууллагын санхүүжилтээр 3000 хувийг хэвлэн та бүхэнд хүргэж байна.

Биднийг дэмжиж тусалцаа үзүүлсэн НҮБ-ын Сайн Дурын Байгууллагын хөтөлбөрийн зохицуулагч Нира Шарма мөн зураач С. Төгс-Оюун нарт талархал илэрхийлж, ажлын их амжилтыг хүсэн ерөөе.

Орчуулсан:	Б. Нандинчимэг
Хянасан:	Н. Чинчулуун Д. Пүрэвсүрэн
Хэвлэлд бэлтгэсэн:	Н. Энхцэцэг Б. Байгалмаа
Зураач:	С. Төгс-Оюун
Хаяг:	Сүхбаатар дүүрэг, Бага тойруу, 6-р хороо, 44-р байр, 4 тоот
Утас/Факс:	317904
Вэб сайт:	www.mones.org.mn
И-майл:	mones@mongol.net



VSO Олон Улсын Байгууллага

VSO нь 1958 онд байгуулагдсан Англи улсад төвтэй олон улсын, төрийн бус байгууллага бөгөөд 1991 оноос Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

2005–2010 онд ажиллах хэтийн төлөвлөгөөний дагуу боловсрол, эрүүл мэнд, тогтвортой амьжиргаа болон үндэсний сайн дурынхан гэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. VSO-ийн сайн дурынхны хөтөлбөрийн үйл ажиллагаа нь сайн дурын үйл ажиллагааны талаарх олон нийтийн ойлголт нэмэгдүүлэх, сайн дурынхантай ажилладаг байгууллагуудын чадавхийг дээшлүүлэхэд чиглэж байна.

Манай хөтөлбөрийн үйл ажиллагааг дэмжиж, хамтарч ажилладаг Сүлжээний гишүүн байгууллагууд болон дэмжлэг үзүүлдэг Монголын Эмэгтэйчүүдийн Сан, Монголын Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Сан, НҮБ-ийн Сайн Дурынхны Хөтөлбөр зэрэг байгууллага, хамт олонд баярлаж байдгаа энэ ялдамд илэрхийлье.

Энэ чиглэлээр хамтарч ажиллах сонирхолтой бол танай байгууллага, хамт олон Монголын Сайн Дурын Байгууллагуудын Сүлжээнд нэгдэн орж болно.

Сайн дурын үйл ажиллагааны талаар мэдээлэл, материал, сургалт, зөвлөлгөө хэрэгтэй бол Монголын Сайн Дурын Байгууллагуудын Сүлжээний гишүүн байгууллагууд болон VSO-д хандаарай.

Хаяг: Болор бизнес төв, Улаанбаатар–13,
Шуудангийн хайрцаг–678
Утас/Факс: 976–11–318514, 318515
www.mongolia.vsoint.org

**НҮБ-ын САЙН
ДУРЫНХАНЫ
БАЙГУУЛЛАГА**



НҮБ-ын Сайн дурынхны байгууллага нь 1970 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн шийдвэрээр байгуулагдсан бөгөөд НҮБ-ын XX-н удирдлага дор үйл ажиллагаагаа явуулдаг. Тус байгууллага нь сайн дурын үйл ажиллагааг идэвхжүүлэн сайн дурынхныг урамшуулан тэтгэх замаар дэлхий дахинд хүний тогтвортой хөгжлийг хангахад чиглэн ажилладаг.

НҮБ-ын Сайн дурынхны Байгууллага 1986 оноос Монголд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд тус байгууллагын зорилго нь:

- Ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжлийг хангах зэрэг үндэсний тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд сайн дурынхны хувь нэмрийг өсгөх замаар засгийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
- Тухайн орны Засгийн газар, төрийн болоод төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийнхэн, сургууль соёлын газруудад сайн дурынхны тоог нэмэгдүүлэх
- Монгол дахь сайн дурын байгууллагуудын хамтын ажиллагааг улам батжуулах явдал юм.

Монголд нийт 179 сайн дурын мэргэжилтнүүд ажилласны 45 хувь нь эрэгтэй, 55 хувь нь эмэгтэй хүмүүс байлаа. Тэдгээрээс 91 нь ОУ-ын Сайн дурын мэргэжилтэн, 73 нь Үндэсний Сайн дурын мэргэжилтнүүд байсан бөгөөд 2 нь UNISTAR буюу НҮБ-ын ОУ-ын Богино Хугацааны Мэргэжилтнүүдийн Сангийн шугамаар ажилласан байна.

Бид НҮБ-ын Сайн дурын мэргэжилтнээр хилийн чанадад ажиллах Монголчуудын тоог өсгөхийг зорьж байгаа бөгөөд одоогоор 2 хүн энэ чиглэлээр ажиллаж байна.

Өнөөдөр НҮБ-ын Сайн дурын мэргэжилтнүүд ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжлийг хангах, эрүүл мэнд, мэдээллийн технологийг хөгжүүлэх зэрэг олон салбарт ажиллаж байгаа билээ. НҮБ-ын Сайн дурын мэргэжилтэн болохын ач тус нь дэлхийн олон орноос ирсэн мэргэжилтнүүдээс суралцаж тэдэнтэй сурсан мэдсэнээ хуваалцах явдал байдаг. Монгол орон НҮБ-ын Сайн дурынхны байгууллагын томоохон хөтөлбөр бүхий орнуудын тоонд багтдаг юм.

Сайн дурын үйл ажиллагаа нь өөрийгөө хөгжүүлэн бусадтай хуваалцах замаар нийгэмдээ хувь нэмэр оруулах ариун үйлс юм.

Манай хаяг: НҮБ-ын байр, НҮБ-ын шудамж-12,
Ш/х-49/2078 НҮБ-ын XX/НҮБ-ын СБД, Улаанбаатар хот
Утас: 325911, 323365, Факс: 326221
E-mail: all.unv.mn@undp.org

ГАРЧИГ

Оршил		6
1. Сайн дурын үйл ажиллагаа гэж юуг хэлэх вэ?, Түүний хэлбэр, шинж чанар		8
· “Volunteerism” хэмээх нэр томъёоны тухай, тэдгээрийн илэрхийлж буй ухагдахууны онцлог ба ялгаа		8
· Сайн дурын үйл ажиллагааны хэлбэрүүд, тэдгээрийг тодорхойлох нь		10
2. Сайн дурын ажилтан гэж хэн бэ?		13
· Сайн дурын үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулах нь ямар ач холбогдолтой вэ?		15
· Сайн дурын ажилтнуудад зориулсан зөвлөмжүүд		15
3. Сайн дурын үйл ажиллагаа, бусад онцлог асуудлууд болон түүнд уриалан дуудах нь		24
· Даяарчлал		24
· Сайн дурын үйл ажиллагаа ба төр, засгийн газрын хамтын ажиллагаа		25
· Сайн дурын үйл ажиллагаа ба зах зээлийн харилцаа, уялдаа холбоо		26
· Сайн дурын ажилтан болон орон тооны ажилтнуудын хамтын ажиллагаа		27
· Сайн дурын үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулж, бусдын төлөө хандив өргөсөн үзүүлэлт /5 орны жишээгээр/		28
4. Сайн дурын үйл ажиллагаа ирээдүйд		29
· Сайн дурын үйл ажиллагаа ба түүний ирээдүйн зураглал		29
· Сайн дурын үйл ажиллагаанд хүчин зүтгэх ерөнхий стратегии хандлагууд		30
5. Сайн дурын үйл ажиллагаа дэлхийн зарим орнуудад		34
6. Дэлхий нийтийн сайн дурын үйл ажиллагаанд эмэгтэй сайн дурынхны гүйцэтгэх үүрэг		39
7. Сайн дурын үйл ажиллагаа – Монголд		40

Оршил

1995 онд Данийн Копегаген хотноо хуралдсан “Нийгмийг хөгжүүлэх тухай дэлхийн дээд хэмжээний чуулга уулзалт”-нд 117 орны төлөөлөгчид оролцож ядуурлыг буруулах, ажлын байр нэмэгдүүлэх асуудлыг дэмжих, нийгмийн аюулгүй байдлыг хангах талаар хэрэгжүүлэх үндсэн арван чиглэлийг нийтээр хүлээн зөвшөөрч тунхагласан байна. Копегагений уулзалтын үеэр сайн дурынхны эрхэм үйл ажиллагааг тусгайлан зааж хэсэгчлэн дурьдаагүй ч нийгэм, эдийн засгийн салбарыг хөгжүүлэх үйлсэд сайн дурынхан, нийгмийн сайн дурын бүлгүүдийн оруулах хувь нэмэр асар их бөгөөд ямагт чухал байр суурь эзэлж байдгийг дурьджээ.

Уг уулзалтаас гарсан үр дүнгийн хэрэгжилтийг хангах тухай хэлэлцэхээр Ерөнхий ассемблей 1999 оны 5 сард хуралдсан бөгөөд бэлтгэл ажлын хороо байгуулах тусгай хуралдааны үеэр Япон улсын Засгийн газар нийгмийг хөгжүүлэх үйлсэд сайн дурынхны гүйцэтгэх үүргийн ач холбогдлыг онцлон тэмдэглэж энэ тухай 2000 оны 6 сарын тусгай хуралдаанаар тусгайлан хэлэлцэхийг санал болгосон юм.

Уг тусгай хуралдаанаар 2001 оныг Олон Улсын сайн дуранхны жил болгохтой холбогдуулан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Сайн дурын ажилтнууд дээр дурьдсан асуудлаар танилцуулга тайлан бэлтгэн танилцуулах ёстой бөгөөд цаашид авах арга хэмжээний талаар санал санаачлага гаргахаар болсон байна.

Тайлан бичих бэлтгэл ажлын хүрээнд шинжээчдийн ажлын хэсэг байгуулагдаж дэлхийн өнцөг булан бүрт сайн дурын ажилтанар ажиллаж байгаа олон мянган хүнийг төлөөлж 13 мэргэжилтэн, түүнчлэн НҮБ-ын Нийгмийн асуудал хариуцсан хэлтэс, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Хүний Хөгжлийн Илтгэл хариуцсан алба, НҮБ-ын сайн дурынхны байгууллага болон Дэлхийн банкны ажилтнууд оролцсон байна. Уулзалт хэлэлцээр Их Британы Сайн Дурынхны судалгааны институтын доктор Жастин Смитийн боловсруулсан “Нийгмийн хөгжил ба сайн дурын үйл ажиллагаа” сэдэвт илтгэлийн материалыг хэлэлцэж эхэлсэн юм.

Энэхүү уулзалтаас сайн дурын үйл ажиллагаа нь аж үйлдвэрийн болоод хөгжиж байгаа орнуудын хөгжил дэвшил, нийгмийн хамгааллын салбарт туйлын чухал үүрэг гүйцэтгэдгийн зэрэгцээ энэ нь ихэнх төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоод, худалдааны

байгууллагуудын холбоод, Засгийн газрын анхаарлаас гадуур хоцорч буй үйлчилгээний салбаруудын үйл ажиллагааны үндэс, цөм болж байна гэдгийг цохон тэмдэглэсэн байна. Цаашилбал, сайн дурын үйл ажиллагаа гэдэг нь сая сая залуучууд, хөгшид, тахир дутуу иргэд, гэр бүл болон бусад нийгмийн бүлгүүдийн нийгэм, соёл, эдийн засгийн амьдралд хөл тавьж, гар бие оролцох гол хэрэгсэл, гүүр нь болдог гэжээ. Гэвч сайн дурын үйл ажиллагааны хэр хэмжээ, нөлөөллийн талаар томоохон хэмжээний илтгэл тайлан бичиж онцлон тэмдэглэдэггүй, сайн дурын үйл ажиллагаанд идэвхи санаачилгаараа хүчин зүтгэж байгаа хувь хүмүүсийн ур чадвар, хүсэл эрмэлзлэлийн талаархи бодлогын чанартай арга хэмжээний ач холбогдол үндэстний болоод олон улсын түвшинд туйлын хязгаарлагдмал байгааг тодорхойлсон байна.

Хэрвээ бид сайн дурынхны үйл ажиллагаанд онцгойлон анхаарч ажиллавал дэлхий дахины нийгмийн хөгжил болоод тухайн нэг улс гүрний хөгжлийн төлөө хувь нэмрээ оруулах хүсэлтэй үндэстэн, улс гүрэн бүрийн авьяас чадвартай иргэд хүчээ нэгтгэн ажиллах боломжийг нээж өгөх юм.

САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ГЭЖ ЮУГ ХЭЛЭХ ВЭ? ТҮҮНИЙ ХЭЛБЭР, ШИНЖ ЧАНАР

Сайн дураараа аливаа үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулах явдал нь бараг бүх соёл иргэншилт нийгмийн салшгүй хэсэг байсаар иржээ.

Сайн дураараа аливаа үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулах явдал нь хувь хүн бий биенээ дэмжин амьдрах гүн хүсэл эрмэлзэлтэй байдгийн илэрхийлэл болсон байгалиас заяасан жам ёсны мөн чанар юм. Сайн дурын үйл ажиллагаа нь бусдын тусын тулд үйлчлэх хүсэл эрмэлзэл бөгөөд эн тэргүүнд бусдын аз жаргал, сайн сайхныг бодох хандлага байдаг. Өөрөөр хэлбэл сайн дураар нэгдэх нь бусдын тусын тулд үйлчилэх хүсэл эрмэлзэл юм.

Сайн дураараа туслана гэдэг нь тухайн хувь хүний сэтгэлийн угаас үзүүлсэн дэмжлэг байдаг ба яаж туслав, ямар үр дүн өгөв гэдэг нь тухайн хүний сэтгэл хангалуун явахад нөлөөлдөг.

Үйлдвэржиж байгаа болон хөгжиж байгаа орнуудын нийгмийн сайн сайхан байдал ба хөгжил дэвшил, Үндэсний болон НҮБ-ын хүрээнд хэрэгжиж байгаа хүмүүнлэг тусламжийн хөтөлбөр, техникийн хамтын ажиллагааны тусламж, энхийн үйл хэрэгт сайн дурынхны гүйцэтгэж байгаа ажлууд тооны төдийгүй чанарын хувьд онцгой байр суурьтай болж байна. Төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоод, Үйлдвэрчний эвлэлүүд, бусад олон нийтийн байгууллагуудын үйл ажиллагааны дийлэнх нь сайн дурын үйл ажиллагааны үндсэн дээр тулгуурлаж явагддаг. Бичиг үсэгт сургах, халдварт өвчний эсрэг дархлаа тогтоох болон байгаль орчныг хамгаалах зэргээр олон салбарт явуулж байгаа төрөл бүрийн компани ажилд сайн дурынхны оролцоо зүтгэл зайлшгүй шаардагддаг билээ.

VOLUNTARISM ба VOLUNTEERISM хэмээх нэр томъёоны тухай, тэдгээрийн илэрхийлж буй ухагдахууны онцлог, ялгаа

“VOLUNTARISM” гэдэг нэр томъёо нь эртний нэр томъёо бөгөөд энэ нь аливаа нэг зүйлийг сайн дураараа хийж гүйцэтгэхийг илэрхийлсэн утгатай ажээ. Тухайлбал АНУ-д шашныг сайн дураараа шүтэн бишрэх явдал *voluntarism*-д тооцогддог байна. Энэ нь бүхий л

сайн дурын үйл ажиллагааг өөрийн утганд агуулдаг боловч “voluntarism” гэсэн нэр томъёоны хам утганд хэрэглэгдэж буй “сайн дурын гэсэн утгатай “voluntary” гэдэг үг нь хуулиар заагаагүй гэсэн санааг илтгэдэг. Сайн дурын олон салбарууд, (ашгийн бус) агентлагууд хуулинд заасан шаардлагын дагуу сайн дурын удирдах зөвлөлтэй байдаг боловч сайн дурын ажилтнуудаа ямар нэг байдлаар шууд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд оролцуулдаггүй.



Харин “VOLUNTEERIM” гэдэг нэр томъёог Харриет Нейлор гэгч хүн анх гаргаж ирсэн бөгөөд 1970-аад оны үеэр Иван Шайер гэдэг хүн байгууллагаа төлөөлөх нэр болгон хэрэглэсэн түүхтэй аж. (Сайн Дурын Үйлсийн талаарх Үндэсний Мэдээллийн Төв). Яг энэ үед хаа нэгтгээ хэн нэгэн кибернетик, бит гэх зэрэг олон зуун мянган үг нэр томъёог шинээр бүтээж байлаа.

Үүнээс үзвэл сайн дурын үйлсэд хүчин зүтгэх, сайн дурын ажилтнаар ажиллах аливаа нэг асуудалтай холбоотой зүйлийн талаар ярьж бичихэд хүрвэл “volunteerism” гэдэг нэр томъёо илүү оносон хэрэглээ болно. Зарим хүмүүс “voluntarism” гэдэг нь ашгийн төлөө бус аливаа орчин гэсэн ухагдахуунд үндэслэсэн бол “volunteerism” гэдэг нь биеэр хийж гүйцэтгэх үйл ажиллагаанд үндэслэсэн утгатай гэлцдэг. Гэвч бидний үзэж байгаагаар хамгийн гол нь “volunteerism” ямар орчинд байгаагаас үл хамаарсан сайн дурын үйлсийг илэрхийлдэг. Ийм ч учраас энэ нэр томъёоны хүрээнд засгийн газрын бүхий л түвшний агентлаг хамрагдаж сайн дурын ажилтантай байж болдог байна.

Хэрэв бид “volunteerism” гэсэн нэр томъёог хэрэглэвэл бид юуны тухай ярьж байгаагаа төвөггүй ойлголцож болно. Тухайлбал, төлөвлөх шаардлагатай ажил бүх талаар дэмжин туслах гэх мэтээр бидний яриа юунд хамаатай байгааг хялбар мэдэж болно. Тиймээс ч та бүхнийг сайн дурын үйл ажиллагаатай холбоотой ажиллагаа явуулдаг бол “volunteerism” гэдэг нэр томъёог хэрэглэхийг санал болгож байна. Ер нь англи хэлэнд “voluntary” гэдэг нэр томъёо нь зарим үед

албадлага, зориуд гэсэн санааг илэрхийлдэг бол "volunteer" гэдэг нэр томъёо нь сайн дураараа гэсэн утгыг зуун хувь илтгэдэг байна.

Сайн дурын үйл ажиллагааны хэлбэрүүд, тэдгээрийг тодорхойлох нь

Сайн дурын үйл ажиллагааг ямар нөхцөлд, ямар орчинд явуулж байгаагаас шалтгаалан төрөл бүрийн хэлбэр, ангилалд хуваадаг. Ялангуяа тухайн бүс нутгийн түүх, улс төрийн байдал, шашин шүтлэг, соёл зан заншил үүнд онцгой нөлөө үзүүлнэ. Тухайлбал, хөдөлмөрийн хөлс бага буюу, илүү цагаар ажиллуулдаг горим тогтсон улсад сайн дурын үйл ажиллагаа гэж юу вэ гэдэг тухайд олон ойлголтыг төрүүлж болно.

Ер нь сайн дурын үйл ажиллагаа үндсэн гурван гол шинж чанартай байна.

1. Сайн дурын үйл ажиллагааг санхүүгийн шагнал урамшуулал авах зорилгын үүднээс хийгээгүй байх ёстой. Гэвч тухайн үйл ажиллагааг явуулахад сайн дурын ажилтнаас шаардагдсан зардлыг нөхөн төлөхийг зөвшөөрдөг.
2. Сайн дурын үйл ажиллагааг сайн дураараа, хувь хүний өөрийн хүсэл зорилгын үүднээс хийсэн байвал зохино.
3. Сайн дурын үйл ажиллагаа нь сайн дурын ажилтнаас өөр хэн нэгэнд ашиг, олз авчрах зорилгогүй байх ёстой. Сайн дурын аливаа үйл ажиллагаа нь тухайн үйлсийг бүтээж байгаа сайн дурын ажилтанд тодорхой хэмжээгээр ач холбогдолтой, үр нөлөөтэй байдаг.

Дээр дурдсан шинж чанаруудыг харгалзан үзсэний эцэст сайн дурын үйл ажиллагааг үндсэн дөрвөн хэлбэрт ангилж болох юм.

Үүнд:

- харилцан туслалцаа үзүүлэх буюу өөртөө туслах сайн дурын үйл ажиллагаа,
- бусдад энэрэн нигүүлсэх үйлсийн үйлчилгээ үзүүлэх сайн дурын үйл ажиллагаа,
- нийгмийн төлөөх аливаа үйл ажиллагаанд оролцох сайн дурын үйл ажиллагаа,
- бусдыг өмгөөлж, тэднийг хамгаалах, компанид ажилд оролцох сайн дурын үйл ажиллагаа зэрэг болно.

Гэвч энэхүү сайн дурын үйл ажиллагааны хэлбэрүүд улс гүрэн бүрт өөр өөрийн гэсэн онцлогтой, ялгаатай байж болно. Өөрөөр хэлбэл сайн дурын үйл ажиллагаанд тухайн орны эдийн засаг, нийгэм, улс төрийн нөхцөл байдал, түүний хөгжлийн үе шат зэрэг нь нөлөөлөх хүчин зүйл болдог байна.

• Харилцан туслалцаа үзүүлэх буюу өөртөө туслах сайн дурын үйл ажиллагаа

Ихэнх хөгжиж буй орнуудад нийгэм эдийн засгийн дэмжлэг үзүүлэх гол тогтолцоо нь харилцан туслалцаа үзүүлэх буюу өөртөө туслах сайн дурын үйл ажиллагаа байдаг. Хамаатан садны энгийн харилцаанаас эхлэн зээлийн үйлчилгээ үзүүлдэг холбоод, нийгмийн хамгааллын бүлгүүдийн



эрхэлж буй үйл ажиллагаа хүртэл тухайн орны нийгмийн хамгааллын салбарт хэрэгжиж буй харилцан бие биедээ туслалцаа үзүүлэх буюу өөртөө туслах сайн дурын үйл ажиллагааны илэрхийлэл болдог байна. Өөртөө туслах хэмээх энэхүү үйл ажиллагаа нь аж үйлдвэр хөгжсөн дэлхийн хойд хэсгийн орнуудад ч онцгой чухал байр суурь эзэлдэг. Ялангуяа эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарт тодорхой нэг өвчин эмгэгтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд туслах олон тооны байгууллагууд байгуулагдан нийгэмдээ үйлчилж байна.

• Бусдыг энэрэн нигүүлсэх сайн дурын үйл ажиллагаа

Бусдад энэрэн нигүүлсэл үзүүлэх сайн дурын үйл ажиллагаа нь өөртөө туслах сайн дурын үйл ажиллагаатай харьцуулбал туйлын өвөрмөц, хэдийгээр энэрэн нигүүлсэх үйл ажиллагаа тухайн хувь хүний өөрийн сонирхлын нэг бүрэлдэхүүн хэсэг болдог ч сайн дурын үйл ажиллагааны үр дүнг хүртэгч нь сайн дурын ажилтан өөрөө бус, гадны гуравдагч этгээд байдаг онцлогтой. Сайн дурын ийм маягийн үйл ажиллагааг сайн дурын болоод олон нийтийн байгууллагуудын хүрээнд явуулдаг. Гэвч зарим орнуудад сайн дураараа энэрэн нигүүлсэх үйлсэд оролцох явдал нийгмийн салбарт уламжлал болсон

байхын зэрэгцээ түүнд хүчин зүтгэх сонирхол аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын дунд өсөн нэмэгдэж байна. Үүнээс гадна хөгжлийн болоод хүмүүнлэгийн туслалцаа үзүүлэх зорилгын үүднээс сайн дурын ажилтнуудыг дэлхийн Хойд бүсийн орнуудаас өмнө бүсийн орнуудад, өмнө бүсийн орнуудаас Хойд бүсийн орнуудад илгээх явдал уламжлал болсоор ирсэн юм.

• **Нийгмийн төлөөх аливаа үйл ажиллагаанд оролцох сайн дурын үйл ажиллагаа**

Нийгмийн төлөөх аливаа үйл ажиллагаанд оролцох сайн дурын үйл ажиллагаа нь удирдан зохион байгуулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд засгийн газрын төлөөлөл болсон зөвлөх албадын төлөөлөгчдөөс эхлэн орон нутгийн хөгжлийн төслүүдэд ажиллаж байгаа хувь хүмүүсийн гүйцэтгэх үүргийг тодорхойлно. Сайн дурын үйл ажиллагааны нэг хэлбэрийн хувьд энэ нь улс гүрэн бүрт нийтлэг байдаг бөгөөд нийгмийн оролцоог дэмждэг орнуудад илүү өргөн хэрэглэгддэг. Копенгагены дээд хэмжээний чуулга уулзалтын үеэр олон нийтийн оролцоо бол удирдлагын сайн тогтолцооны нэгэн салшгүй хэсэг гэж үзсэн бөгөөд энэ нь сүүлийн жилүүдэд улс орны нийгмийн хөгжлийг хэмжих нэг хэмжүүр болж ирлээ. Гэвч оролцоог хэт дэмжиж ажилласнаас гадны хүний зөвлөмж шийдвэрийг эрх зүйн акт болгон баталгаажуулах явдал гарсаар байна гэж шүүмжлэх явдал заримдаа тохиолддог.

• **Бусдыг өмгөөлж, тэднийг хамгаалах буюу компанит ажилд оролцох сайн дурын үйл ажиллагаа**

Бусдыг өмгөөлж, тэднийг хамгаалах, компанит ажилд оролцох сайн дурын үйл ажиллагааг сайн дурын ажилтнууд, заримдаа идэвхтнүүд зохион байгуулж тахир дутуу иргэдийн эрхтэй холбоотой эрх зүйн өөрчлөлт хийхэд засгийн газартаа нөлөөлөх, лоббидох, арьсний өнгөөр ялгаварлан үзэх арга хэмжээг эсэргүүцэх, газрын баялаг ордыг замбараагүй олборлох явдалтай дэлхий нийтээрээ тэмцэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг. Сайн дурынхан ДОХ-ын халдвар авсан хүмүүсийн нийгмийн хамгааллын үйлчилгээний талаар шинэ санал



санаачлан боловсруулж, хүний эрхийг зөрчих, байгаль орчныг сүйтгэн бохирдуулах явдалтай тэмцэх олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх, дэлхийн өнцөг булан бүрт эмэгтэйчүүдийн хөдөлгөөн, ардчилалын компанит ажил явуулах үйлсэд идэвхийлэн оролцсоор ирсэн билээ. Сайн дурынхны зохион байгуулсан зарим компанит ажил орон нутгийн шинжтэй байхад зарим нь дэлхий нийтийн компанит ажил болж чадсан байна.

Жишээлбэл: байгалийн баялаг, ашигт малтмалын ордыг замбараагүй ашиглах явдалтай тэмцэх компанит ажилд 100 гаруй орны 300 сая гаруй сайн дурын ажилтнууд оролцжээ.

II. САЙН ДУРЫН АЖИЛТАН ГЭЖ ХЭН БЭ?

Сайн дурын үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулах нь ямар ач холбогдолтой вэ?

Сайн дурын үйл ажиллагаа нийгэмд үр ашгаа өгөөд зогсохгүй тухайн сайн дурын ажилтанд ч мөн тодорхой хэмжээгээр үр нөлөө авчирдаг. Копенгагены тунхаглал, үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасны дагуу сайн дурын үйл ажиллагаа нь нийгмийн хөгжлийн салбар, ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх гэсэн гурван үндсэн салбарт тодорхой хэмжээгээр хувь нэмрээ оруулж зохих үүрэг гүйцэтгэсэн байх ёстой ажээ.

Нэгдүгээрт, сайн дурын үйл ажиллагаа нь тухайн нийгэмд эдийн засгийн чухал хувь нэмэр оруулдаг. Сайн дурын үйлсэд хүчин зүтгэх талаар улс даяараа анхааран ажилладаг хэд хэдэн орнуудад Үндэсний Нийт Бүтээгдэхүүний үйлдвэрлэлд оруулсан сайн дурынхны хувь нэмэр хамгийн багадаа 8–14 % гэж тооцогджээ. Сайн дурын үйл ажиллагаанд оролцохыг хүсэж, авъяас чадвараа зориулахыг хүсэж байгаа хувь хүмүүс өөрийн ажлын цагаа харамгүй зарцуулж, тэтгэвэрийн насаа сайн дурын үйл ажиллагаанд зориулан, зарим залуус сургуулиасаа чөлөө аван энэхүү эрхэм үйлсэд зүтгэж, хөдөлмөр эрхлэх эмэгтэйчүүдийн тоо ч нэмэгдэж байгаа явдал засгийн газарт нөлөөлөн тухайн орны бүх ард иргэдэд бүхий л салбарт сайн дураараа ажиллаж болох таатай орчин нөхцлийг бүрдүүлэх асуудалд төрөөс анхааран ажиллах болжээ.

Хоёрдугаарт, олон нийтийн оролцоог дэмжих явдал аливаа

нийгмийн хөгжил, удирдлагын сайн тогтолцооны салшгүй хэсэг болж ирсэн. Иймээс ч сайн дурын үйл ажиллагаанд оролцоно гэдэг хувь хүн иргэнийхээ үүргийг биелүүлж итгэл үнэмшилтэй, илүү тогтвортой нийгэм байгуулахад хувь нэмрээ оруулж байгаа гэсэн үг.

Гуравдугаарт. сайн дурын үйл ажиллагаанд оролцох нь нэгэн хэв загварт орж гадуурхагдаж байгаа мэт сэтгэгдэл төрж суугаа тухайн хүмүүст нийгэмдээ илүү ойртож, нийгэмд эзлэх өөрийн байр сууриа олж авахад тусладаг. Жишээлбэл сайн дурын үйл ажиллагаанд оролцож байгаа тахир дутуу иргэд хэн нэгний анхаарал халамжийг хүртээд сууж байгаа идэвхигүй иргэн байсан сөрөг байдлаасаа гарахад энэхүү эрхэм үйлс тусалжээ. Үүний нэгэн адилаар сайн дурын үйлсэд хүчин зүтгэж байгаа залуучуудад өөрийгөө хөгжүүлэх, амьдарч ажиллаж буй нийгэмдээ бие хүн болон төлөвшихөд үнэтэй дадлага, сургууль нь болдог байна. Харин сайн дурын үйл ажиллагаанд оролцож буй настайчууд тэтгэвэртээ гараад удаагүй, ажлын байргүй болоод байгаа амьдралын шинэхэн хэв маягаа зохицож биеийн болон оюуны зохих хөдөлмөр эрхэлж идэвхитэй амьдрах эерэг ач холбогдолтой юм.

Дөрөвдүгээрт. сайн дурын үйлс нь ажилгүй хүмүүсийг ажлын байраар хангах асуудалд онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг. Цалин хөлстэй ажил хайж байгаа хүмүүс сайн дураараа аливаа үйл ажиллагаанд оролцох нь өөртөө итгэх итгэлийг төрүүлж, ажлын байртай болох асуудлаа илэрхийлж болох хүмүүстэй танилцан тодорхой харилцаа холбооны сүлжээнд орж зах зээлийн ур чадварт суралцах боломж олгодог. Сайн дурын үйл ажиллагаанд хүчин зүтгэх нь шинэ ажлын байр буй болгох замыг нээж өгөх бөгөөд, хэрэв та үр бүтээлтэй, шаардлагатай үйлчилгээг санаачилж чадвал төрийн аливаа байгууллага таны ажлыг дэмжиж хамтран ажиллаж хожим цалинтай ажилтай болж болох юм. Жишээлбэл сайн дурын ажилтнуудын санаачилсан ДОХ-ын аюулаас сэргийлэх дэлхий нийтийн аян төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн салбарт олон мянган хүмүүсийг ажлын байртай болгосон юм.

Тэгэхээр сайн дурын үйл ажиллагаа нь нийгэмд үр дүнгээ өгөөд зогсохгүй уг сайн дурын ажилтанд өөрийгөө хөгжүүлэх, нийгэмд тодорхой байр суурь эзлэхэд нь ач тусаа өгдөг, өөрөөр хэлбэл хоёр талын ач холбогдолтой байна. Сайн дурын үйл ажиллагаа нийгэмд эдийн засгийн чухал дэмжлэг үзүүлдэг ба үүнээс илүү гэж үзэж болох нэг ач холбогдол нь илүү бат бөх, нягтаршил бүхий хүмүүсийн

нийтлэгийг бий болгодог, өөрөөр хэлбэл хүмүүсийн хоорондын итгэлцлийг бэхжүүлж хүмүүсийн нөхөрлөлийг зайлшгүй тогтвортой байлгах эв санааны нэгдэл, хамтран ажиллах эрмэлзлийн хэм хэмжээг хөгжүүлэхэд тусалдаг.

Сайн дурын ажилтнуудад зориулсан зөвлөмжүүд

Хүмүүс яагаад сайн дурын үйл ажиллагаанд оролцдог вэ?

Хүмүүс төрөл бүрийн шалтгааны улмаас ялангуяа бусдад тусламж дэмжлэг үзүүлэхийг хүссэн үедээ сайн дурын үйл ажиллагаанд оролцдог. Гэхдээ сайн дурын ажилтнууд өөрсдийн эрх ашиг, тусын тулд энэхүү үйл ажиллагаанд оролцдог байж болно. Ихэнх хүмүүс “сайн дурынхан” сайн дурын үйл



ажиллагаанд оролцсоноор асар их “ашиг” олдог гэж ойлгодог. Ер нь түүхээс үзэхэд сайн дурын үйл ажиллагааг хувиа бодох үзэлгүй, нийтэч, энэрэнгүй сэтгэлгээтэй өглөг буяны нэг хэлбэр гэж үзэж иржээ. Сайн дурын үйл ажиллагааны дотроос бусдын төлөө гэсэн сэтгэлээр хүсэл эрмэлзэл дүүрэн ажиллах нь туйлын эрхэм дээд үйлсэд тооцогддог.

Сайн дурын үйл ажиллагаа нь тань шиг боломж, бололцоотой орчинд төрөх аз дутсан хэн нэгний төлөө аливаа нэг үйлс бүтээх гэсэн утга илэрхийлэхээс гадна энэ нь сайн дурын ажилтан болоод тэдний дэмжлэг авч буй хүмүүсийн аль алинд харилцан ач холбогдол өгдөг өвөрмөц ухагдахуун юм. Зарим хүмүүс өөрийгөө өнөөгийн нийгмийн амьдралд ямар их хэрэгтэй хүн болохыг сайн дурын үйл ажиллагаанд оролцсоноор мэдэрдэг. Өнөөдөр та бусдад туслах боломжтой сайн дурын ажилтан байгаад авьяас чадвараа зориулсан байхад хожим өөр хэн нэгний тус дэмийг сайн дурын үйл ажиллагааны үр шимээр хүртэх ч байж магадгүй шүү дээ. Сайн дурын үйл ажиллагаанд оролцох нь дам утгаараа өөртөө туслаж байна л гэсэн үг. Хөршийнхөө гэрийг гадны халдлагаас хамгаалж байхад хөрш тань таны гэрийг гэмт

халдлагаас хамгаалж байх жишээтэй. Бусдын тусын тулд та хөдөлмөрөө зориулбал хүн бүрийн амьдрал дээшилнэ гэдгийг ямагт санаж явах нь зүйтэй.

Сайн дурын үйл ажиллагаанд оролцох болсон шалтгаан

Яагаад та сайн дурын үйл ажиллагаанд оролцож байгаагаа бодож байх хэрэгтэй. Танд сайн дураараа бусдад туслах хэд хэдэн шалтгаан байдаг байж болно. Үүнээс гадна сайн дурын ажилтнуудаас авсан асуулга судалгаанд үндэслэн сайн дурын ажилтнууд дараах шалтгааны улмаас энэхүү эрхэм үйлсэд гар бий оролцдог байна. Үүнд:

- өөрийгөө мэдрэх мэдрэмжтэй болно
- бусадтай сурсан эрдэм, ур чадвараа хуваалцана
- оршин амьдарч байгаа нийгмээ мэддэг болно
- бусдыг удирдах ур чадвартай болно
- иргэнийхээ үүргийг биелүүлэх боломжтой болно
- найз нөхөд, хамаатан саднууд сайн дураараа ажиллахыг санал болгосон учраас
- сайн дурын үйл ажиллагаанаас гарах үр дүнд сэтгэл хангалуун байдаг учраас зүгээр суухгүйн тулд
- ерөө төлөхийн тулд
- мэргэжлийнхээ ур чадвараар бусдад тус дэм болохын тулд
- хэн нэгэн үүнийг хийх ёстой гэж боддог учраас
- бусдад сайнаар нөлөөлөхийн тулд
- шинэ зүйлд суралцахын тулд
- хатуу чанд цагийн хуваариар ажилладаг, эрх чөлөөтэй байхын тулд
- найз нөхөд, хамаатан садандаа туслахын тулд
- гэм буруугаа цагаатгахын тулд
- өөртөө итгэлтэй болохын тулд
- өөртөө сэтгэл хангалуун, бардам байхын тулд
- шинэ найз нөхөдтэй болно
- ажил мэргэжлийн талаар өсөх ирээдүйтэй болно
- хэн нэгэнд туслана
- өөрт минь аль ч талаар эмчилгээ болно
- ажлаасаа өөр ямар нэгэн сонирхолтой зүйл хийхийн тулд
- зугаатай, хөгжилтэй байдаг тул
- шашны сүсэг бишрэлийн улмаас

- хичээлийн кредит цаг нөхөж авахын тулд
- өөрт буй ур чадвараа хий дэмий мөхөөхгүйн тулд
- газар зүйн байршил ойрхон учраас
- дуртай зүйлээ хийхийн тулд
- шүүмжлэхийн тулд
- хөгжин дэвшихийн тулд
- үргэлж сайн сайхан сэтгэгдэлтэй байхын тулд
- хамт олонтой байхын тулд
- өөрийн нийгэмд эзлэх байр сууриа олж мэдэхийн тулд
- өөрийгөө сорихын тулд
- ажлын туршлагаа баяжуулахын тулд
- хувь хүнийхээ хувьд өөрчлөгдөхийн тулд
- өөрөө тухайн шалтгааны улмаас (амьдралын бэрхшээл, өвчин зовлон гэх мэт) зовж шаналж үзсэн учраас
- хөл дээрээ зогсохын тулд, биеэ даах чадвартай болохын тулд

Дээрхийн адил та ч гэсэн сайн дурын үйл ажиллагаанд оролцох өөрийн гэсэн шалтгаантай л байгаа шүү дээ. Гэхдээ яагаад сайн дурын үйлсэд зүтгэж байгаа шалтгаан нь чухал биш бөгөөд хамгийн гол нь нэгэнт сайн дурын ариун үйлсэд хүч хөдөлмөрөө зориулж байгаа бол таны хичээл зүтгэл ямар нэг үйлийг бүтээлцэж, таны авъяас чадварыг хэн нэгэн үнэлж, та өөрчлөгдөж байна гэдэг нь чухал байдаг. Ялангуяа хамтарч ажиллаж байгаа хүмүүстэйгээ ажиллахад туйлын тааламжтай байдаг бол бүр ч сайн. Сайн дурын үйл ажиллагаанд оролцсоноор та сэтгэл хангалуун баяр баясгалантай байгаа бол энэ нь танд ч бас ач холбогдлоо өгч байгаа хэрэг биш гэж үү? Үнэндээ сайн дурын үйл ажиллагаанд оролцсоноор танд болон таны тусалж байгаа хүмүүст хэрхэн яаж нөлөөлөв гэдгийг ажиглан харж чадвал таны цаашдын сайн дурын үйлс улам эрч хүчтэй, урам зоригтой байх болно. Та өөрөө ч үр дүнг нь хүртдэг болохоор сайн дурын ажилтан байх нь "өглөг буяны" байгууллагад ажилласнаас илүү таатай нөхцлийг бүрдүүлдэг.

Өөрт тохирсон боломжийг хайж олох нь чухал

Сайн дурын үйл ажиллагааг олон салбарт өргөн ашигладаг бөгөөд тэдгээрийн дотроос чухам танд тохирох ажлыг олж авах хэрэгтэй байдаг. Ингэхийн тулд дараах асуудлуудыг анхааралтай бодож үзээрэй. Үүнд:

Би ямар асуудлыг илүү сонирхдог вэ?

Таны сонирхож байгаа асуудлаар уйл ажиллагаагаа явуулдаг ямар байгууллага байдаг вэ? Тухайн байгууллагуудыг та хангалттай сайн ажиллаж байна гэж боддог уу, таны туслалцаа тэдэнд шаардлагагүй гэж үздэг үү? Уг байгууллагад та хандив өргөж байсан уу? Таны хандивыг зарцуулсан байдалд та сэтгэл хангалуун байдаг уу?

Эдгээр асуултанд хариулснаар та ямар төрлийн байгууллагад сайн дурын ажилтнаар ажиллахыг хүсэж буйгаа төвөггүй мэдэж болох юм.

Та одоо хийж буй ажил, мэргэжлийнхээ ур чадварыг сайн дурын үйл ажиллагаандаа зориулахыг хүсэж байна уу? Эсвэл өөр ямар нэгэн шинэ зүйл туршиж үзэхийг хүсэж байна уу?

Та юуг хамгийн сайн хийж чаддаг вэ? Та ямар зүйлийг хийх дуртай вэ? Эдгээр нь ажил мэргэжил, таны сонирхдог зүйл (хобби), амралт чөлөөт цагаараа хийх дуртай зүйлүүдийн аль нь ч байж болно. Хүний хийж чаддаг ямар ч зүйл хаа нэгтэй хэрэгтэй л байдаг. Сайн дурын ямар ажилд та хувь нэмрээ оруулж чадах вэ гэдгээ мэдэж байвал танд тохирсон сайн дурын үйл ажиллагаа олоход хялбар байх болно.

Сайн дурын ажилтанд тавигдах энгийн ажил мэргэжлийн шаардлага гэж байдаг. Тухайлбал: компьютер дээр ажиллаж чаддаг байх гэх мэт. Гэхдээ хамгийн гол шалгуур нь хүнтэй харьцах чадвартай, бусдыг сонсож чаддаг, хөгжилтэй, аливаа зүйлийг шүүмжилж байнга сөргөөр хардаггүй, бусдаддаа үргэлж тусалдаг гэх мэт үзүүлэлтүүд байдаг.

Өөрт байгаа ур чадвараа жагсааж бичсэний дараа өөрөөсөө "Сайн дурын үйл ажиллагаанд оролцоходоо би энэ ур чадваруудаа ашиглах уу?" гэж асуу. Хэрвээ та өдөр тутмынхаа амьдралыг өөрчлөхийг хүсэж байгаа бол байнга хийж дадсан зүйлийг тань хийхийг шаардах сайн дурын байгууллагыг сонгохгүй л болов уу.

Сайн дурын ажилтан болсноор би юунд суралцахыг хүсэж байгаа вэ?

Сайн дурын ажилтны хувьд та шинэ шинэ үйл ажиллагааг сэдэж турших эрх чөлөөг эдэлнэ. Зарим байгууллагууд сайн дурын ажилтан үргэлж шинийг эрэлхийлж, шинийг санаачилж байдгийг мэддэг учраас тэднийг энэ талаар дэмждэг. Ингэхээр сайн дурын ажилтан

байна гэдэг нэг талаар таны нуугдмал шинэ авъяасчадварыг тань нээх сонирхолтой аян болдог байх юм. Өөрийгөө янз бүрийн үйл ажиллагаанд туршиж, ур чадвараа шалгах нь танд өдөр бүр шинэ соргог сэтгэгдэл төрүүлнэ.

Сайн дурын ажилтны хувьд та ямар зүйлийг хийхийг хүсэхгүй вэ?

Сайн дурын ажилтны хувьд би ийм зүйлүүдийг хийхийг хүсэхгүй байна гэж хэлэх нь тийм ч таагүй зүйл биш. Хийхийг хүссэн зүйлээ хийх нь таныг маш сайн ажилтан болгоно. Хэн нэгний санал болгосон зүйлд заавал "За" гэж хариулах албагүй гэдгийг санаж яваарай. Харилцан ярилцаж зөвшилцөх хэрэгтэй шүү дээ.

Сайн дурын ажилтнаар хир удаан ажиллахыг хүсэж байна вэ?

Үргэлжилсэн удаан хугацаагаар, богино хугацаагаар эсвэл зөвхөн ганц удаагийн үйл ажиллагаанд оролцох байдлаар гэх мэт. Зарим сайн дурын үйл ажиллагаа удаан хугацаанд явагддаг. Харин зарим нь богино хугацаанд явагддаг, нэг өдрийн сайн дурын үйл ажиллагаа ч гэж байдаг. Олон зуун байгууллагууд оройн цагаар эсвэл амралтын өдрүүдээр хийж болохуйц сайн дурын үйл ажиллагааг төлөвлөн явуулдаг бөгөөд энэ нь богино хугацаанд зохиогдож байгаа ч асар их ач холбогдолтой байдаг. Хамтран ажиллаж байгаа байгууллагадаа та тухайн сайн дурын үйл ажиллагаанд оролцох боломжтой, боломжгүй эсэх талаар болон цагтаа очиж чадах эсэх талаар шударга шулуун хандах хэрэгтэй байдаг. Таныг ирж оролцоно, оролцохгүй гэдэг талаар хамтрагч байгууллага, алба тань мэдсэний үндсэн дээр ажлаа төлөвлөнө шүү дээ. Ер нь сайн дурын үйл ажиллагаанд оролцож эхлэхдээ хэдэн цагаар хийх ажилд оролцож эхлэх нь зүйтэй. Дараа нь боломжтой бол ажиллах цагаа сунгаж болно шүү дээ. Энэ нь их амлаад биелүүлж чадалгүй хожим эвгүй байдалд орохоос тань сэргийлнэ.

Би ганцаараа ажиллах уу, эсвэл найз нөхөд, гэр бүл, өөр хэн нэгэнтэй хамтарч ажиллах уу? Би сайн дурын ажилтны сургалтанд хамрагдахыг хүсэж байна уу? Эсвэл шууд л сайн дурын үйл ажиллагаанд оролцоод эхлэх үү? Би ямар хүмүүстэй ажиллахыг хүсэж

байна вэ? Сайн дурын ажилтнаар элсүүлэхийг хүсэж аливаа байгууллагад хандахдаа би ямар бэлтгэл хийх ёстой вэ?

Ихэнх байгууллагууд таны ажил, мэргэжил, хүсэл сонирхол, намтар түүхийн талаар сонирхож асуулт асуудаг. Түүнээс гадна ямар байгууллагад хандсан болоод сайн дурын ямар үйл ажиллагаанд оролцуулах гэж байгаагаас шалтгаалан таныг шууд ярилцлагад урьж магадгүй юм. Цаашилбал сайн дурын ажилтны анкет бөглөх ч шаардлага гарч болно.

Хэрвээ таны оролцох гэж буй сайн дурын үйл ажиллагаа хүүхдүүд болон бусад нийгмийн эмзэг бүлгийн хүмүүстэй харьцах ажил байвал тухайн байгууллага таныг ажил байдлын тодорхойлолт, гэмт хэрэгт холбогдолгүй болохыг гэрчлэх баримт материал авчрахыг шаардаж болно. Үүнд эмзэглэх хэрэггүй. Хууль бол хууль шүү дээ. Энэ нь хүүхэд, хөгшин настай хүмүүст тусалж, тэднийг хамгаалж байгаагийн нэг илрэл юм.

Сайн дурын ажилтнаар элсүүлэхээр шийдсэн тохиолдолд таныг сайн дурын ажилтны сургалтанд урьж магадгүй. Харин 18, түүнээс доош насны хүмүүс энэхүү шийдвэрийг гаргахдаа асран хамгаалагч, эцэг эхтэйгээ ирж шийддэг.

Эцэст нь хамтран ажиллахаар хүсэж байгаа байгууллага, албадаас сонирхсон асуултаа чөлөөтэй асууж, харилцан бий биенээ судлах боломжийг олгох хэрэгтэй.

Сайн дурын ажилтан шаардлагатай байгаа тухай мэдээллийг би хаанаас авч болох вэ?

Сайн дурын ажилтан хэрэгтэй байгаа байгууллагыг тодорхойлох, олж авах хэд хэдэн арга зам бий. Сонирхож буй байгууллага уруугаа утасдаж сайн дурын ажилтан элсүүлдэг тухай асууж сураглаж болно. Цалин хөлстэй ажилд орохын тулд яаж хөөцөлддөг билээ, түүнтэй л адил асууж сураглаж мэдээлэл цуглуулах хэрэгтэй. Таныг хийхийг хүсэж буй зүйлийг тань дэмжиж ажиллах байгууллага олдохгүй бол өөрийн санал санаачилгыг хэрэгжүүлэхийн тулд та өөрөө шинэ байгууллага, алба байгуулж болно. Бүх зүйл тэгээс эхэлдэг. Хийе гэсэн хүсэл, бусдад туслая гэсэн сэтгэл байвал хамтран ажиллагчаа та хэзээ ч олно.

Өөрт тохирсон ажил гэдгийг хэрхэн мэдэх вэ?

Хэдийгээр сайн дурын үйл ажиллагаа ч гэсэн зөвхөн танд зориулсан мэт гэж хэлж болохоор ажлаа оллоо гэдгээ хэрхэн мэдэж болох вэ?

- Сайн дурын ажилтнаар элсэхийг хүсэж байгаа байгууллагатайгаа танилцахын тулд очиж үзэх хэрэгтэй, гүйцэтгэх албаны ажилтнууд, сайн дурын ажилтнуудтай уулзаж ярилцаж үз. Сайн дурын ажилтны ямар хөтөлбөртэй вэ гэдгийг судал. Байгууллагын танилцуулгыг уншиж юуны төлөө ажилладаг, ямар зорилго, зорилттой байгууллага болохыг мэдэж авах нь зүйтэй.
- Тухайн байгууллагаас яагаад сайн дурын ажилтнуудтай ажилладаг эсэх болон сайн дурын ажилтан байгууллагын зорилго зорилтыг хэрэгжүүлэн биелүүлэхэд ямар үүрэг гүйцэтгэх талаар асууж тодруулаарай. Эндээс тухайн байгууллагын хувьд сайн дурын ажилтан ямар үнэ цэнэтэй болохыг хялбар мэдэж болно.
- Сайн дурын ажилтны ажил үүргийн хуваарийг бичгээр авч сонирхоорой. Сургалтанд хамрагдах боломжтой эсэх, ямар хугацаагаар ажиллах эсэх зэргийг тодруулахад ч буруудахгүй. Сайн дурын ажилтны асуудал хариуцсан хүнтэй уулзаж ярилцах хэрэгтэй.
- Тэвчээртэй бай: Сайн дурын үйл ажиллагаа гэхээр л сайн дурын ажилтан бүрт зориулагдсан байдаг юм биш. Олон байгууллагаар явж судлаарай. Энэ ажил танд тохирохгүй бол таныг хүлээж буй өөр олон байгууллага бий гэдгийг санаарай.

Гэр бүлээрээ сайн дурын үйл ажиллагаанд оролцох нь

Хэрвээ та бусад хүмүүсийн нэгэн адил амьдардаг бол өдөрт ердөө хэдэн цаг л чөлөөтэй байдаг байх. Даргын өгсөн даалгаврыг биелүүлэх, хүүхдүүдийнхээ хүсэж буй зүйлийг хийх гээд танд цаг зав бага гардаг нь мэдээж хэрэг. Хэдийгээр бусдад туслах хүсэл эрмэлзэл байсан ч ийм завгүй байж яаж сайн дурын ажилтан болох вэ гэж та бодож ч магадгүй юм.

Гэр бүлээрээ сайн дурын гишүүн болох нь энэ асуудлыг хялбархан зохицуулна. Гэр бүлээрээ сайн дурын гишүүн болно гэдэг нь гэр бүлийн бүх гишүүд эсвэл зарим нь (аав, хүү хоёр, ээж, охин хоёр гэх мэт) сайн дурын ажилтан болохыг хэлнэ. Тэгээд ч таны ажиллаж байгаа

байгууллага олон хүний тус дэмжлэг авч ажилдаа туслуулахдаа баяртай байх болно. Гэр бүлээрээ сайн дурын үйл ажиллагаанд оролцсоноор ямар ач холбогдолтой вэ? Нэгдүгээрт, гэр бүлийн гишүүд хамт байх цаг нэмэгдэж, бие биенийгээ өөр нөхцөлд илүү сайн таньж мэдэх боломж олгоно. Үүнээс гадна хийж гүйцэтгэж байгаа ажлаасаа шалтгаалан бие биенээ хүндэтгэх, нэгэн зорилгын төлөө сэтгэл нийлж ажиллах, долоо хоногийн турш ярих сэдэв өргөн болох гээд ач холбогдлыг тоочоод баршгүй. Цаашилбал өмнө нь та дангаараа сайн дурын ажил хийдэг байсан бол гэртээ өнгөрүүлэх цаг бага байна гэж гомдоллох хүн байхгүй болно.

Сайн дурын ажилтан болохыг хүсэж байна уу? Та 18 нас хүрсэн үү?

Хэрвээ та 18 нас хүрээгүй хүүхэд боловч сайн дурын ажилтан болохыг хүсэж байвал яах вэ? Хэдэн настайгаас үл хамааран өөрийн чадлын хэмжээнд сайн дураараа бусдад туслаж байвал энэ нь сайн хэрэг. Үнэхээр сайн дурын ажилтан болохыг хүсэж байвал танд сонголт олон бий. Нэгдүгээрт, бусдад туслаж, дэмжлэг үзүүлдэг залуучуудын байгууллагад элсэж болно. Нэгэнт тухайн байгууллагын гишүүн учраас аливаа сайн дурын үйл ажиллагаанд оролцох боломж нээгдэнэ гэсэн үг. Үүнээс гадна та олон найз нөхөдтэй болно. Хоёрдугаарт, таны суралцаж буй сургууль дээр сайн дурын үйл ажиллагаа явуулдаг дугуйлан, клуб байдаг бол түүнд элсэж болно. Гуравдугаарт, та хувь хүнийхээ хувьд сайн дурын үйл ажиллагааг санаачлан зохион байгуулж болно. Гэхдээ та ямар шалтгааны улмаас юуг сайн дураараа хийх гэж байгаа нь хамгийн чухал байдаг.

Ихэнх байгууллагууд таны насанд тохирсон үйл ажиллагааг сайн дурын ажилтны хувьд хийхийг танд санал болгодог. Үнэхээр тухайн байгууллагын хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, үйл ажиллагааны зорилго таны таалалд нийцэж байвал тэдэнд туслахад юу нь буруудах билээ. Тухайлбал:

- Хэлмэрчээр ажиллах
- Интернет, компьютерийн хэрэглээ (зарим томчууд яаж ашиглахаа мэддэггүй)
- Тухайн өдөр хийвэл зохих бага сага туслах ажил
- Нөхөрсөг, найрсаг, нийтэч байх
- Биеийн хүчний ажил хийх гэх мэт

Сайн дурын үйл ажиллагаанд оролцох нь хүсэл мөрөөдлөө биелүүлэх нэг алхам мөн.

Сайн дурын үйл ажиллагаанд оролцох нь заримдаа хүмүүсийг хоосон мөрөөдөлд умбан амьдрах амьдралын хэв маягаас гарахад тусладаг. Бид бүгд л ганц олох амьдралаа сонирхолтой, утга учиртай өнгөрүүлэхийг хүсдэг. Зарим нь бүр арслангийн аманд гараа хийж үзэх юмсан, амь эрссэн үйл бүтээхсэн гэж мөрөөддөг. Иймээс хүч хөдөлмөрөө зориулах гэж буй сайн дурын үйл ажиллагаагаа сонгож авахдаа өөрөө өөрийгөө нээх боломж олгох ажлыг сонгож авах нь зүйтэй.

Жишээлбэл та шоу бизнест дуртай юу? Хэрэв дуртай бол олон байгууллагад таны туслалцаа хэрэгтэй болох юм байна даа. Хэдийгээр та дуулж, бүжиглэж чадахгүй ч тайз засал, хувцас оёх, тасалбар худалдах гээд олон ажлаар тэдэнд туслаж чадна шүү дээ.

Та өөрийгөө цагаан халадтай эмч хүн гэж төсөөлж байсан уу? Улаан загалмайн нийгэмлэгт сайн дурын ажилтнаар элсэж тэдний ажилд туслаж болно. Ингэснээрээ та хэн нэгний амь насыг аврах чухал үйлс бүтээж байна гэсэн үг. Иймээс өөрийн тань дотоод сэтгэл таныг хааш нь хөтөлнө, түүнийг даган хүсэж мөрөөдсөн зүйлээ биелүүлэхийн тулд сайн дурын үйлсэд хүчин зүтгээрэй.

Сайн дурын ажилтан байх нь ажил мэргэжлийн хувьд өсөх ирээдүй байгаа эсэхийг мэдэхэд тусалдаг.

Ажил мэргэжлийн хувьд хаана өсөх ирээдүй байна вэ гэдгийг та боддог бизээ. Эсвэл ажлаа солихыг хүсэж байж ч болзошгүй. Сайн дурын үйл ажиллагаанд оролцох нь ажил мэргэжлийн хувьд өсөх ирээдүй хаана байгааг олж тогтоож болох тааламжтай нөхцлийг бүрдүүлдэг. Богино хугацаанд сайн дураараа хийж гүйцэтгэж байгаа учраас тухайн ажлыг хийхэд танд эрсдэл багатай байна гэсэн үг. Иймээс танд энэ нь нэг ёсны туршилт болно. Танд тохирохгүй ажил гэдгийг ухаармагц та тухайн ажлыг хийхээ больж болно, харин танд таалагдаж байгаа сонирхолтой ажлаа олсон бол сайн дураараа ажиллах цагаа нэмэгдүүлж авъяас чадвараа бүрэн зориулах нь зүйтэй. Цаашилбал сайн дурын ажилтан болох нь хожим таныг цалинтай ажилтай болоход туслах олон хүмүүстэй танилцуулж өгнө. Ялангуяа төгсөх ангийн оюутнууд сайн дурын ажилтан болох нь тухайн албан байгууллагад өөрийгөө таниулах өргөн боломжийг нээж өгдөг.

Зарим хүмүүс хийж байгаа ажлаасаа уйдсан байдаг. Тийм хүмүүст

сайн дурын үйл ажиллагаанд оролцох нь нэг ёсны шинэлэг зүйлийг нээх зам болдог. Шинэ нөхцөл байдалд, шинэ ажил хийхэд танд ямар санагдах бол? Туршаад л үз.

Хүндэтгэх шалтгааны улмаас ажлаасаа гарсан боловч авьяастай, чадвартай, боловсролтой олон хүмүүс байдаг. Ийм хүмүүст өөрийн ур чадвартай, авьяастай хэвээр байгаагаа нотлох арга зам бол сайн дурын ажилтан болох явдал юм.

Тэтгэвэртээ гарсан хөгшчүүдэд сайн дурын ажилтан болох нь нэг ёсны хоёр дахь мэргэжил нь болдог гэж болно. Сайн дурын үйл ажиллагаанд оролцох нь тэдэнд өөрийгөө залуу, эрч хүчтэй хэвээр байгаа сэтгэгдэл төрүүлдэг юм.

III. САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БУСАД ОНЦЛОГ АСУУДЛУУД БОЛОН ТҮҮНД УРИАЛАН ДУУДАХ НЬ

Даяарчлал

Сайн дурын үйл ажиллагаа буй болоход даяарчлал ихээр нөлөөлсөн гэж болно. Дэлхийн хойд бүсэд орших аж үйлдвэр хөгжсөн олонх хөгжингүй орнуудад шашин номонд сүсэглэх хүний тоо буурч, уламжлалт гэр бүлийн холбоо харьцангуй холдож хувь хүний биеэ даасан байдал давамгайлж байгаа учраас сайн дурын ажилтны тоо буурах хандлагатай болж магадгүй байна. Ялангуяа цалинтай ажлыг илүүд үзэх болсон зарим орнуудад сайн дурын ажилтан олоход туйлын бэрхшээлтэй байдаг тухай зарим сурвалж бичигт дурджээ. Ялангуяа бусдыг халамжлан асрах салбарт ажиллах сайн дурын ажилтны тоо эрс буурчээ. Гэтэл 1999 оны НҮБ-ын Хүний Хөгжлийн Илтгэлд бусдыг халамжлан асрах хөдөлмөр бол тухайн нийгмийг тогтвортой хөгжүүлэх нэгэн салшгүй хүчин зүйл болно гэсэн байна. Иймд хүний хөгжлийн асуудал даяарчлалаас үүдэн хязгаарлагдмал хүрээнд орж байгааг тус илтгэлд дурдаад энэ тухай улс орон бүр, иргэн бүр анхаарч үзэхийг уриалсан байна.

Нөгөө талаас даяарчлал бүхэлдээ сайн дурын үйлсэд сөрөг нөлөө үзүүлж байсангүй. Дэлхийн нийт хүн амын дундаж наслалт харьцангуй байдаг ч сайн дурын үйл ажиллагаанд хүн амын гурав дахь насны ангилалынхан (настайчууд) илүү идэвхтэй, санаачилгатай оролцож

нийт сайн дурын ажилтны тоог тодорхой хэмжээгээр өсгөж байгаа юм. Харилцаа холбооны технологи өндөр хурдацтай хөгжиж нийгэмд ойр амьд холбоо харилцааны хувь буурч байгаа ч сайн дурын ажилтнууд өөр шинэ шинэ арга замыг хайн энэхүү эрхэм үйлсээ бүтээсээр явна. Интернетийг ашиглах нь аливаа хүмүүст санаа бодлоо солилцох, туршлага солилцох асар их боломжийг олгодог техникийн эх сурвалж болоод байна. Иймээс хүмүүст гэрээсээ аливаа сайн дурын үйл ажиллагаанд оролцох ялангуяа тахир дутуу хүмүүст энэ боломжийг ашиглах таатай нөхцлийг бүрдүүлж байна. Түүнээс гадна Интернетийн сүлжээ залуучууд, хөгшчүүдийн хоорондын харилцааны гүүр болж насны зааг ялгаагүйгээр бий биенээсээ суралцах замыг нээлээ.

Сайн дурын үйл ажиллагаа ба Төр, Засгийн газрын хамтын ажиллагаа

Засгийн газар, зах зээлийн хуулиар сайн дурын үйл ажиллагаа нь төр болоод бизнесийн аливаа салбарын анхаарлаас гадуур үлдсэн нийгэм, эдийн засаг, соёл боловсрол, шинжлэх ухааны ямарваа үйлсийг соргог олж харж түүнийг нийгмийн хөгжилтэй хамт урагш



явахад нь тус дэм үзүүлж ажиллах ёстой гэж үздэг. Энэ нь сайн дурын ажилтнуудын олж ажигласан зүйлийг хожим Засгийн газар дэмжиж төр, үндэсний хөтөлбөрийн хэмжээнд асуудал болгон дэвшүүлж ч болно гэсэн үг юм.

Сайн дурын ажилтнууд хүний бодит хэрэгцээ, шаардлагыг олж харж чаддаг бөгөөд түүнийг шийдвэрлэх шинэ үйлчилгээ, ажлыг санаачилахад онцгой чухал үүрэг гүйцэтгэж ирсэн билээ. Буяны эмнэлэг байгуулах хөдөлгөөн өрнүүлж, ДОХ-ын халдвар авсан хүмүүст үзүүлэх халамж, үйлчилгээний асуудлыг санаачилсан нь сайн дурынхны хийсэн томоохон ажлуудын жишээ юм. Гэвч төр байхгүй бол сайн дурын үйлс амжилт олж чадна гэж хэлэх баталгаа байхгүй. Сайн дурын ажилтнуудын оролцож буй үйл ажиллагаанд олон нийтийн бусад байгууллагууд дэмжлэг үзүүлдэг. Сайн дурын үйл ажиллагаа нь нийгэмд үйлчилж түүгээр бас тэжээгдэж байдаг онцлогтой.

Сайн дурын үйл ажиллагааг төрөл бүрийн арга хэлбэрээр зохион

байгуулж явуулж болох учраас түүний нэгдсэн нийтлэг хэлбэр гэж байдаггүй. Улс үндэстэн бүр өөрийн гэсэн өвөрмөц зан заншил, уламжлалт соёл, шашин шүтлэгтэй байдаг учраас нэг улсад амжилттай хэрэгжиж байсан сайн дурын үйл ажиллагаа нөгөө улсад төдийлөн их амжилт олохгүй байж болно. Сайн дурын үйл ажиллагаа нь хүрээлэн буй орчныхоо бүтээгдэхүүн нь байдаг учраас Баруун Европ, Латин Америк эсвэл Өмнөд Африкт сайн дурын ажилтныг дэмжих талаар авч хэрэгжүүлж байгаа засгийн газрын бодлого нөгөөдөө тохирохгүй байж болно. Гэвч энэ нь харилцан туршлага солилцож, алдаа дутагдлаасаа суралцахыг үгүйсгэж байгаа хэрэг бус юм.

Сайн дурын үйл ажиллагааг Засгийн газраас дэмжих дараах нийтлэг арга замууд бий. Үүнд: сайн дурын үйл ажиллагааны талаарх стратеги хандлага боловсруулах, сайн дурын үйлсийн талаарх олон нийтийн ойлголтыг эерэгээр сайжруулах, залуучуудыг сайн дурын үйлсэд уриалж, тэднийг хөхүүлэн дэмжих, сайн дурын үйл ажиллагааг явуулах орчин, нөхцлийг бүрдүүлэх, хувийн хэвшлийн салбарын дэмжлэг тусалцааг сайшаан урамшуулах, гадаадын байгууллагуудад нөлөөлөх зэрэг болно. Засгийн газраас сайн дурын үйл ажиллагааг дэмжихэд чиглэгдсэн аливаа үйл ажиллагаа дараахь зарчмыг баримтлах ёстой. Үүнд:

- Тухайн орны нөхцөлд тохирсон сайн дурын үйл ажиллагааг дэмжих бодлого боловсруулах
- Сайн дурын үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага, хүмүүстэй хамтарч ажиллах
- Сайн дурын үйл ажиллагааны биеэ даасан байдлыг хүлээн зөвшөөрч тухайн төр, засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгасан зүйлийг хийхийг шаардахгүй байх зэрэг болно.

Сайн дурын үйл ажиллагаа ба зах зээлийн харилцаа, уялдаа холбоо

Сүүлийн жилүүдэд олон нийтийн салбарт сайн дурын үйл ажиллагаанд оролцох сонирхол асар ихээр нэмэгдэж байна. Ялангуяа нийгэмдээ томоохон хөрөнгө оруулалт хийх стратеги боловсруулах, гүйцэтгэх ажилтнуудыг мэргэжлийн болоод хүнийх нь хувьд хөгжүүлэх зэрэгт анхаарч зорилгоо биелүүлэхийн тулд сайн дурын үйл ажиллагааг идэвхтэй зохион байгуулж түүнд ажилтнуудаа хамруулж байна. Ингэхдээ зохион байгуулалт, менежментийн төрөл бүрийн

хэлбэрийг ашиглаж байна. Зарим ажил олгогчид компани, байгууллагаараа сайн дурын үйл ажиллагаанд оролцох ажлыг зохион байгуулж байна. Зарим байгууллага ажилтнуудаа төрийн бус байгууллагуудад ажиллуулах замаар сайн дурын үйлсэд хувь нэмрээ оруулж байна. Сайн дурын үйлсэд ямар ч хэлбэрээр оролцож болох бөгөөд ажил олгогч ажилтнуудаа сайн дурын үйл ажиллагаанд оролцоход нь дэмжлэг үзүүлбэл тэдний мэдлэг, мэргэжлийн ур чадвар, ёс зүйн ухамсар нь дээшилж байгууллагадаа хандах хандлага сайжрахын зэрэгцээ нийгэмд тухайн байгууллагын бизнес тогтворжиж бэхждэг болох нь тогтоогджээ.

Сайн дурын ажилтан, орон тооны ажилтнуудын хамтын ажиллагаа

Сайн дурын ажилтнуудын хүсэл зоригийг мохоодог нэг зүйл бол тухайн байгууллагын орон тооны ажилтнууд болон удирдах албаны ажилтнууд байдаг гэж тооцдог байна. "Орон тооны ажилтнууд сайн дурын гишүүдийг ойлгон хүндэтгэж, тэдэнд итгэл үнэмшилтэй ханддаг бол илүү их амжилтанд хүрнэ" гэж ихэнх сайн дурын ажилтнууд үздэг байх юм. Иймээс тухайн байгууллагад шинээр сайн дурын гишүүн болон элссэн ажилтанд орон тооны ажилтны хувьд хэрхэн хандах, туслах талаар байгууллагын бүх ажилтнууд бэлтгэгдсэн байх ёстой. Сайн дурын ажилтан ажил үүргийн ямар хуваарьтай болох, байгууллагын зорилго, хөтөлбөрийн хэрэгжилтэнд ямар үүрэг гүйцэтгэхээ мэдэхгүй байгаа тохиолдолд орон тооны ажилтан яаж туслах вэ? гэсэн асуулт хамгийн чухал.

Ажилтан бүр ажил үүргийн тодорхой хуваарьтай байдаг нь мэдээж хэрэг. Гэвч үнэн хэрэгтээ цаасан дээр бичиж гарын үсэг зурсан ажил үүргийн хуваариас хол илүү ажлыг хүн бүр өдөр тутам хийж гүйцэтгэж байдаг. Иймээс ажилд орохдоо хүлээж авсан ажил үүргийн хуваарьтай харьцуулбал одоо таны хийж гүйцэтгэж байгаа ажил байгууллагынхаа хувьд та ямар үүрэгтэй хүн бэ гэдгийг тодорхойлоход илүү ойлгомжтой байх болно. Сайн дурын ажилтны хувьд ч энэ бичигдээгүй хууль үйлчилнэ. Сайн дурын ажилтнууд ямагт хэн нэгний хүссэн, гуйсан зүйлийг хийхэд туслах байдлаар ажлаа эхэлдэг.

Сайн дурын ажилтан, орон тооны ажилтны хамтын ажиллагаа нэгдүгээрт хэн ямар ажил эрхэлдэг болохыг танилцахаас эхэлнэ.

Хоёрдугаарт,

- Сайн дурын ажилтан гадны хүн мэт сэтгэгдэл төрөхөөргүй нөхцөлд орон тооны ажилтан мэт ажиллах ёстой.
- Сайн дурын ажилтан тухайн байгууллагынхаа орон тооны ажилтнуудын хоорондох нөхөрсөг өрсөлдөөнийг нэмэгдүүлнэ.

Аливаа байгууллагын орон тооны ажилтнууд, удирдлага, даргаасаа эхлээд хаалгач нь хүртэл илүү цагаар ажиллах явдал байнга тохиолддог. Ийм ч учраас бид сайн дурын ажилтны дэмжлэг туслалцааг авахаар тэднийг байгууллагынхаа гишүүнээр элсүүлдэг. Иймд орон тооны ажилтнууд ажлын бус цагаар сайн дурын ажилтанд байнга туслаж, ажил үүргийнх нь хувьд дэмжлэг үзүүлж байх үүрэгтэй. Гэхдээ тухайн албан хаагч ажлын ачаалал ямар байгаагаас шалтгаалан удирдлагын зүгээс хүсэлт тавих хэрэгтэй юм.

Нөгөө талаас сайн дурын ажилтны дэмжлэг туслалцааг авахын тулд тухайн ажилтан өөрөө ямар ажил хийж, юуны төлөө тэмүүлж байгаагаа сайтар ухаарсан байвал зохино.

Сайн дурын үйлсэд хувь нэмрээ оруулж, бусдын төлөө хандив өргөсөн үзүүлэлт (5 орны жишээгээр)

Асуулга/асуулт	Англи	Канад	Франц	Испани	АНУ
Өглөг, буян хандив өргөдөг хүн амын хувь	65%	62%	27%	71%	55%
Хандивын дундаж хэмжээ (US\$ / 1 сард)	14%	43%	8%	15%	38%
Буяны байгууллагад сайн дурын ажилтнаар ажилладаг хүн амын хувь	15%	25%	10%	11%	20%
Сайн дураар ажилладаг цаг (цаг / сард)	1.8	5.2	1.6	1.6	2.2
Өглөг, хандивыг ямар салбарт хандивласнаар нь ангилбал					
Нийгмийн хамгаалал					
(настайчууд, асрамжийн газар)	14%	11%	2%	39%	8%
Шашин шүтлэг	16%	29%	6%	22%	33%
Анагаах ухаан, эрүүл мэнд	23%	29%	11%	6%	7%
Иргэний бобоод нийгмийн холбоод					
(хүний эрхийн холбоо, нийгэмлэгүүд)	5%	10%	4%	3%	7%
Залуучуудын хөгжлийн асуудал	5%	10%	1%	2%	9%
Боловсрол, сургалт хөдөлмөр эрхлэлт	8%	7%	1%	2%	7%
Урлаг, соёл, хүмүүнлэг	2%	5%	1%	1%	2%
Ан амьтан	7%	4%	1%	2%	1%
Олон улсын тусламж	13%	3%	2%	1%	1%

Буяны тусламжийн сангийн судалгаанаас Торонто, 1996 он

VI. САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ИРЭЭДҮЙД

Сайн дурын үйл ажиллагаа ба түүний ирээдүйн зураглал

Америкийн сайн дурын үйл ажиллагааны түүхэн замнал гурван зуун дамжсан баялаг туршлагатай байна. Ер нь сайн дурын үйл ажиллагаанд оролцож байгаа хүмүүсийн тоо чухал биш юм. Харин тухайн үйл ажиллагааны хэрэгжилтэнд сайн дурын ажилтны хувиар оруулсан багахан ч болов хувь нэмэр юу байв гэдэг нь туйлаас чухал. Сайн дурын үйлс хоёр талтай үйл ажиллагаа юм. Сайн дурын үйл



ажиллагаа гэдэг нь сайн дурын ажилтны нүдээр анх олж харсан аливаа зүйлд тодруулбал өнөөгийн нөхцөл байдал, нийгэмд тулгарч байгаа бэрхшээл, олон нийтийн хэрэгцээ шаардлага зэрэгт хариулт болон очиж байгаа үйлдэл билээ. Төр, засгийн газар, мэргэжлийн байгууллага, институтууд тухайн асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагаа явуулахаас өмнө сайн дурын ажилтнууд нийгэмд тулгараад байгаа тухайн бэрхшээлтэй асуудлыг шийдэхийн тулд сайн дураараа ажиллаад эхэлсэн байдаг. Иймээс ч сайн дурын ажилтнууд ямагт шинийг санаачлагч, тэргүүлэгч, үүсгэн байгуулагч, анхдагч, туршигч болсоор иржээ.

Сайн дурын үйл ажиллагааг амжилттай явуулахын тулд үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулан түүнийгээ хамтран ажиллах хүмүүстээ гардуулдаг. Энэ нь сайн дурын үйл ажиллагааны улс төртэй холбоотой байх нэг шалтгаан болдог. Сайн дурын ажилтнуудын зарим нь нийгэмд учирсан бэрхшээлийг даван гарахад хүмүүст туслаж байхад зарим нь тэднийг эрх зүйн хүрээнд хамгаалан тэдэнд нөлөө үзүүлж байдаг байх юм.

Сайн дурын байгууллагууд тухайн байгууллага, албыг санаачилсан анхдагчдынхаа бүтээн босгосон ажил хэргийг тогтвортой үргэлжлүүлэхийн тулд гишүүдийнхээ тоог хязгаарладаггүй. Цаашилбал сайн дурын ажилтнууд мэргэжлийн болоод бусад

байгууллагын бүтэц зохион байгуулалтанд нөлөө үзүүлж чаддаг байна. Сайн дурын нэг ажилтан бусадтайгаа нийлж асуудлыг анхаарч үзнэ. Дараа нь тэдний эгнээ улам бүр өргөжиж олон гишүүнтэй болсноор тухайн асуудлаар хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратеги боловсруулж улмаар санхүүжилт хайна. Санхүүжилт шийдэгдвэл сайн дурын үйл ажиллагаагаа эхэлнэ. Цаашид ч ийм л байх болно.

Сайн дурын ажилтнуудын сэдэж санаачилсан зүйлийг зохицуулж, цаашдын тогтвортой хэрэгжих нөхцлийг хангах хүмүүс бол гүйцэтгэх албаны ажилтнууд юм. Зарим байгууллагын хувьд сайн дурын ажилтнууд зөвхөн сан бүрдүүлж хөрөнгө босгогч, бодлого боловсруулагч, удирдах зөвлөлийн гишүүн гэх зэрэг дэмжигчийн байр сууринаас ажилладаг байна.

Сайн дурын үйл ажиллагаанд хүчин зүтгэх ерөнхий стратеги хандлагууд

Зарим орны төр, засгийн газар сайн дурын үйл ажиллагааг дэмжиж, бизнесын салбар, сайн дурын байгууллагад ажиллаж байгаа хүмүүстэй энэ чиглэлээр хамтарч ажиллах талаар тусгай стратеги боловсруулан ажилладаг байна. Тухайн стратегид юу багтаасан байх нь улс орон бүрийн онцлогоос шалтгаалдаг боловч дараах асуудлыг нийтлэгээр тусгасан байж болох талтай. Үүнд:

- Сайн дурын үйл ажиллагааг дэмжиж, бизнесын салбар, сайн дурын байгууллагад ажиллаж байгаа хүмүүстэй энэ чиглэлээр хамтарч ажиллах асуудлыг зохицуулах бодлого боловсруулах засгийн газраас томилогдсон албыг байгуулах
- Сайн дурын үйл ажиллагааг дэмжих засгийн газрын төсөв батлах
- Төрийн өмчийн салбарт ажиллах сайн дурын ажилтныг хөхүүлэн дэмжих
- Иргэний үйлчилгээний ажилтнуудыг сайн дурын үйл ажиллагаанд оролцох боломжоор хангах
- Сайн дурын ажилтнуудын тоог нэмэгдүүлэхийн тулд үндэсний болоод орон нутгийн хэмжээнд сайн дурын үйл ажиллагааны салбарын дэд бүтцийг үр дүнтэй сайжруулах асуудлыг санхүүжүүлэх зэрэг болно.

Засгийн газраас сайн дурын ажилтан байхын ач холбогдлыг олон нийтэд таниулж сурталчлах, сайн дурын ажилтнаар ажиллах

боломжийг нээлттэй болгож ард иргэдийг мэдээллээр хангах арга хэмжээ авч болно. Жишээлбэл:

- Сайн дурын үйл ажиллагаа, түүний нийгэм, эдийн засгийн салбарт оруулах хувь нэмрийн талаар судалгаа явуулах буюу, судалгааны ажлыг санхүүжүүлэх,
- Сайн дурын үйл ажиллагааны талаар болон сайн дурын ажилтан элсүүлэх мэдээллийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран нэвртүүлэг бэлтгэх ажлыг дэмжих, олон нийтэд эерэг ойлголт төрүүлэхэд нөлөөлөх
- Хүмүүсийг сайн дурын ажилтнаар элсүүлэхийн тулд мэдээллийн технологийг өргөн ашиглах
- Сайн дурын ажилтнуудын оруулсан хувь нэмрийг үнэлэх шагнал урамшууллын тогтолцоог буй болгон олонд алдаршуулах
- Сайн дурын ажилтнуудад зориулсан өдөр тогтоох

Сайн дурын үйл ажиллагаанд оролцох нь залуучуудын хувьд техникийн болон амьдралын туршлага хуримтлуулах гол хэрэгсэл нь болдог. Цаашилбал залуугаасаа эхлэн сайн дурын үйлсэд оролцож байсан хүмүүс бүх л амьдралынхаа туршид энэ салбарт ажилласаар байдаг нь батлагдсан зүйл ажээ. Сайн дурын залуу гишүүдийн тоо зарим улсад буурч байхад зарим орны хувьд энэ тоо байнга өсөж байдаг байна. Ер нь сайн дурын үйл ажиллагааг уламжлалт салбаруудад түшиглэн зохион байгуулж байснаа хожим байгаль орчныг хамгаалах зэрэг өнөөгийн нөхцөлд тохирсон салбаруудад ихээхэн анхаардаг болжээ. Залуучуудын дунд сайн дурын үйл ажиллагаанд оролцох хүсэл эрмэлзлийг төрүүлэхийн тулд төр, засгийн газраас авах арга хэмжээ чухал байр суурь эзлэх бөгөөд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно: Үүнд:

- Боловсролын байгууллага, залуучуудад зориулсан үйлчилгээний салбарт сайн дурын үйл ажиллагааг дэмжин зохион байгуулах
- Сайн дурын залуу ажилтныг урамшуулах тусгай хөтөлбөр боловсруулах
- Сайн дурын үйл ажиллагаанд оролцож байгаа хөдөлмөр, оруулж буй хувь нэмрийг нь үнэлэх тогтолцоог буй болгох, үнэлэх
- Сайн дурын үйл ажиллагааны талаар орчин үеийн, хүмүүсийн анхаарлыг татахуйц хөтөлбөр бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах

Цаашилбал Засгийн газар хууль, эрх зүй, санхүү болон бодлогын шинж чанартай асуудлыг шийдэж сайн дурын үйл ажиллагаа явуулах

таатай нөхцлийг бүрдүүлэх нь төрөөс үзүүлж буй дэмжлэг болно. Тухайлбал:

- Ашгийн бус болон сайн дурын байгууллага, албыг байгуулах болон санхүүжүүлэх эрх зүйн нөхцлийг бүрдүүлэх

Сайн дурынханд зориулсан хөтөлбөрийг сурталчлах 20 гайхамшигтай санал

1. Сайн дурын ажилтнуудад чөлөөт цаг, амрах цаг гаргаж өгөхийн зэрэгцээ материал олшруулах, бичиг баримт эмхлэх зэрэгт туслах ажилтан хэрэгтэй эсэхийг асууж санал болгох

2. Шинээр элсэн орж байгаа ажилтнуудаа “Сайн дурын үйл ажиллагаанд оролцох тухай асуулга анкет” бөглүүлж тэдний сонирхол, ур чадвар, авъяасын талаар тодорхой мэдээлэлтэй болно.

3. Ажилтнуудын сайн дурын үйл ажиллагааны талаар хөтөлбөр боловсруулж тэдний мэргэжлийн болоод сайн дурын үйл ажиллагаанд оролцох өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ авах цаашилбал үүнээс гарах үр дүнг тухайн ажилтантай ярилцах замаар буюу удирдах ажилтантай нь уулзах замаар олж мэдэх

4. Ажилтнууд тань ямар ур чадвартай, авъяастай болохыг ямагт санаж энэ талаар мэдээллийн сантай болсон байх

5. Сайн дурын ажилтнуудад зориулсан хөтөлбөрийн зорилго нь тухайн байгууллагын бизнесийн зорилго хөтөлбөртэй уялдсан байх

6. Байгууллагынхаа сайн дурын ажилтнуудыг хариуцсан мэргэжилтэн ажилтныг тухайн орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байгаа сайн дурын ажилтны байгууллага эсвэл зөвлөлтэй нягт холбоотой ажиллуулах

7. Сайн дурын ажилтнуудын хэрэгжүүлсэн үйл ажиллагааны ололт амжилт, гол чухал онцлог үйл явдлуудын талаар жилийн эцсийн тайлан буюу байгууллагын сэтгүүл, сонин хэвлэлд сурталчилгаа байдлаар хэвлүүлж нийт ажилчид, үйлчлүүлэгчид, захиалагчид нартаа тараах

8. Сайн дурын ажилтнуудад зориулсан хөтөлбөрөө цаг ямагт бэлэн байлгаж сайн дурын ажилтнууд хэрэгцээтэй байгаагаа мэдээлэх мэдээллийн эх сурвалжийг цаг тутам, эсвэл долоо хоног тутам гаргаж байх

9. Амралт – Сайн дурын ажилтан сэдэвт хөтөлбөр боловсруулж олон нийтэд таниулах энэ нь амралтаа авсан хүмүүст тодорхой хэмжээгээр сайн дурын үйл ажиллагаанд оролцох боломжийг нээж

өгөх

10. Тэтгэвэртээ гарах болсон хүмүүст зориулж сайн дурын ажилтнуудын хөтөлбөрийн талаар сургалт семинар зохион байгуулж тэднийг сайн дурын ажилтнуудад зориулсан хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахад уриалан дуудаж төлөвлөх үйл явцад хамруулах

11. Байгууллагынхаа интернет веб хуудсанд сайн дурын ажилтнуудын хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг оруулахын зэрэгцээ тухайн орон нутагт ажиллаж буй сайн дурын байгууллагын интернет веб хуудастай холбоотой байх

12. Сайн дурын ажилтны хөтөлбөрийг танилцуулах зорилгоор ашгийн бус байгууллагууд буюу сайн дурын ажилтнуудын төв байгууллагатай хамтран үдийн зоог барих арга хэмжээ авч болох юм

13. Сайн дурын ажилтнуудыг алдаршуулах самбар байгуулж, тэднийг сайшаан урамшуулал үзүүлэх зорилгоор нэрийг нь бичиж хадах

14. Сайн дурын үйл ажиллагаанд амжилттай оролцсон ажилтнуудаа урамшуулж дуурь, концерт, театрын тоглолт үзэх тасалбар өгөх, байгууллагаас ивээн тэтгэж буй үйл ажиллагаанд оролцохыг урих,хоолонд урих зэргээр дэмжиж болно

15. Сайн дурын ажилтнуудыг өргөн хүрээгээр хамарсан арга хэмжээ зохион байгуулах, тухайлбал өөрчлөлт гаргах өдөр, үндэсний сайн дурынхны долоо хоног гэх мэт олон нийтийг өргөн хамарч болохуйц үйл ажиллагааг төлөвлөн зохиох

16. Сайн дурын үйл ажиллагаанд оюутан залуучуудыг татан оролцуулах талаар тодорхой үйл ажиллагаа явуулах, и-майлээр харьцаж тэдний ирээдүйн мэргэжлийн талаар санал солилцох зэрэг арга хэмжээ авах

17. Сайн дурын үйл ажиллагаанд амжилттай хичээнгүйлэн оролцсон ажилтнуудаа алдаршуулах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр талархал бичиж хэвлүүлэх

18. Сайн дурын үйл ажиллагаанд оролцогчдын дунд төрөл бүрийн урамшуулалт уралдаан зарлаж болно

19. Удирдах зөвлөлийн гишүүд, хувьцаа эзэмшигч, хандивлагчдыг сайн дурын үйл ажиллагаанд оролцохыг урьж болно.

20. Сайн дураараа аливаа үйл ажиллагааг зохион байгуулж оролцон хүмүүсийн тухай цаг ямагт хэвлэлийн мэдээлэл бичиж хэвлүүлэх, сурталчилах арга хэмжээг авч байх хэрэгтэй.

Сайн дурын ажилтнуудыг энэхүү эрхэм үйлсэд татан оролцуулах,

тэднийг сурталчилахдаа сайн дурын үйл ажиллагаа гэдэг нь өглөг буяны үйлсээс эрс ангид өөр, иргэнийхээ үүргийг зөв ухамсарласан шударга ёсны ариун үйлс гэдгийг ухааруулах нь чухал гэдгийг санах хэрэгтэй.

V. САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ДЭЛХИЙН ЗАРИМ ОРНУУДАД

Леван

Тухайлбал сайн дурын үйлс нь Леванчуудын хувьд нэг ёсны амьдралынх нь хэв маяг нь болжээ. Шаардлагатай тохиолдолд хүмүүс бусдад туслахын тулд гар бий оролцон зүтгэх явдал нэгэнт зуршил болон тогтсон байна. Дайны үед бие биедээ туслах, хорогдох байранд хамт орогнож хэцүү бэрхийг туулж байсан явдал хүмүүсийн сэтгэлгээнд нөлөөлсөн гэж үздэг байна. Дайны дараа ч учирсан хохирлыг хамтдаа даван туулж ядуурлаас гарах, эх орноо сэргээн босгох гэж зүтгэж байсан ард түмний сэтгэл үеэс үед уламжлагдан ирсэн ажээ.

Сайн дурын үйл ажиллагааны түвшингээр дэлхийн улс гүрнүүдийг жагсааж үзвэл Леван энэ жагсаалтыг тэргүүлэх нь гарцаагүй. Сайн дурынхны сургалтын хөтөлбөр, мянган мянган сайн дурын ажилтнуудын бүлэг, тэдний зохион байгуулж байгаа үйл ажиллагаа Леванчуудын ухамсарт тунхаглал болсоор ирсэн байна. Сайн дурын үйл ажиллагааны хөтөлбөр нь үндсэн хоёр зорилготой байдаг байна. Үүнд:

- Нийгэмдээ үйлчилж, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах
- Сайн дурын үйл ажиллагааг дэмжих, сурталчилах

Сайн дурын үйл ажиллагаанд оролцож байгаа хүмүүст насны ангилал гэж байдаггүй. Нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулахын тулд сургуулийн сурагч, оюутан, гэрийн эзэгтэй, бүгд өөрийн гэсэн чухал үүрэг гүйцэтгэдэг.

Засгийн газраас сайн дурынхны үйл ажиллагааг дэмжиж Сайн дурынхны үндэсний хороо байгуулсан нь сайн дурынхны үйл ажиллагааг эрх зүйн баталгаатай болгож өгөх, үндэсний стратегийн дагуу төлөвлөгөөт үйл ажиллагаа явуулах зэрэгт туйлын ач холбогдолтой болжээ. Сайн дурынхны үндэсний хороонд Нийгэм Хамгааллын сайд, Залуучууд, биеийн тамирын сайд, Боловсролын

яамны төлөөлөгч, Байгаль орчны яамны төлөөлөгч, Мэдээллийн яамны төлөөлөгч, Леваны их дээд сургуулийн төлөөлөгчид, НҮБ-ын сайн дурын байгууллагын төлөөлөгч, улаан загалмайн холбооны төлөөлөгч төрийн бус байгууллагуудын төлөөлөгчид, хувийн хэвшлийн салбарын төлөөлөгчид, оюутны төлөөлөгчид, олон улсын төрийн бус байгууллагуудын төлөөлөгчид ордог байна.

Австрали

1993 онд Авсралийн биеийн тамирын хороо, нийгэмлэгүүд хамтран сайн дурын ажилтнуудад зориулсан үндэсний хөтөлбөр боловсруулсан байна. Энэ хөтөлбөрийг боловсруулан баталснаар биеийн тамирын байгууллага, агентлагуудад сайн дурынхны тусламж дэмжлэгтэйгээр хөгжих, үйл ажиллагааныхаа хүрээг тэлж байгууллагынхаа цаашдын тогтвортой хөгжлийг хангахад ихээхэн тусламж дэмжлэг үзүүлдэг байна. Хөтөлбөрийн гол зорилго нь сайн дурынхныг нэгдсэн зохион байгуулалттай зохицуулан ажиллаж идэвх санаачилгыг нь унтраалгүй дэмжин ажиллах явдал бөгөөд үүний тулд стратеги бодлого баримтлах шаардлагатайг дурдаад дараах асуудлуудыг зарчим болгон жагсаасан байна. Үүнд:

- Сайн дурынхныг элсүүлэх нь
- Сайн дурынханд байгууллагынхаа зорилго үйл ажиллагааг таниулж, тэднийг тухайн байгууллагын нэг хэсэг гэдгийг ойлгуулах нь
- Тодорхой үйл ажиллагааг зохион байгуулахад оролцсон албан бус сайн дурын ажилтанг удирдах нь
- Сайн дурынхыг удирдан зохион байгуулах бодлого боловсруулах нь
- Сайн дурынхныг асуудлыг хариуцагч, зохицуулагчтай байх нь
- Сайн дурынхныг удирдан зохион байгуулах нь зэрэг болно.

Ер нь сайн дурынхан найз нөхөд, хамаатан садан, хувь хүний танилын шугамаар анх сайн дурын үйл ажиллагаанд оролцож эхэлсэн байдаг. Сайн дурынхныг элсүүлэхдээ байгууллагын эрх ашгийг өмнөө тавилгүй тухайн сайн дурын ажилтанд ямар эерэг нөлөөтэй, үр нөлөө үзүүлж болох талаар эхэлж танилцуулах нь зүйтэй байдаг. Үүнээс гадна хэн нэгний хийхийг хүсээгүй зүйлийг хийлгэж байгаа мэт сэтгэгдэл төрүүлэхгүйн тулд тухайн хийх ажлын үнэ цэнийг ойлгуулах нь хамгаас чухал. Үүнийг хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрөөр дамжуулан сайн

дурын үйл ажиллагааг хийж байгаа хүмүүсийн тухай, тэдний санал санаачилга, гүйцэтгэх үүргийн талаар тайлбарлах замаар ойлгуулж болно.

Харин сайн дурынхныг байгууллага, хамт олны нэгэн чухал хэсэг гэдгийг ойлгуулахын тулд тэдний оролцож буй тухайн үйл явдлаас байгууллагад ямар ашиг орж ирэх, энэ нь байгууллагын үйлчлүүлэгч, гишүүдэд ямар нөлөө үзүүлэх зэргийг таниулж, тэдэнд үзүүлэх урамшуулал, шагнал, сургалтанд хамрагдах боломж, сайн дурын ажилтны хувьд эдлэх эрх, үүргийг байгууллагынхаа эрхэм зорилго, зорилттой уялдуулан тайлбарлаж өгөх хэрэгтэй.

Тодорхой нэг үйл ажиллагааг зохион байгуулахад идэвхийлэн оролцсон албан бус сайн дурын ажилтантай ажиллах нь албан ёсны сайн дурынхантай ажиллахаас өөр байдаг. Учир нь тухайн сайн дурын ажилтны идэвхи зөвхөн нэг үйл ажиллагааг зохион байгуулахад чиглэгдсэн богино хугацаатай байхад албан ёсны сайн дурын ажилтан байгууллагатай илүү ойр ажилладаг урт хугацааны гэрээтэй байх жишээтэй. Гэвч богино хугацаанд ажиллаж байгаа зарим сайн дурынхан илүү чөлөөтэй байдлаар ажиллах боломжтой гэж үздэг байхад зарим нь тухайн үйл ажиллагааг зохион байгуулахад төдийлөн ач холбогдол өгөхгүй байх явдал бий. Иймээс үйл ажиллагааг зохион байгуулагч сайн дурын ажилтанд яагаад, ямар учраас, ямар зорилгоор тухайн үйл ажиллагааг явуулж байгаа болон түүнээс урган гарах үр дүнг танилцуулах нь чухал байдаг.

Ихэнх байгууллагууд сайн дурынхантай ажиллахдаа тэдний өдөр тутмын ажлыг хянаж, зохицуулж өгдөг. Иймээс сайн дурын ажилтантай ажиллах бодлого боловсруулах нь сайн удирдлагын тогтолцоо бүрэлдэх эхлэл болдог. Иймд сайн дурын ажилтан ямар журмын дагуу ажиллах, хувь хүн, сайн дурын гишүүний хувьд ямар эрх үүрэгтэй байхыг зааж өгөхийн сацуу сайн дурын ажилтнуудын хариуцан ажиллах үйл ажиллагааг тодорхойлсон бодлого боловсруулах нь зүйтэй.

Аливаа оронд сайн дурынханыг олох тэдэнтэй ажиллана гэдэг амар зүйл биш юм. Хэрвээ сайн дурынхныг зөв жолоодож, зохион байгуулахгүй бол тэд ямарч дэмжлэггүй, зохицуулалтгүй ганцаардмал байдалд орж улмаар сайн дурын үйл ажиллагааг сөрөгөөр дүгнэж эхэлдэг. Иймээс байгууллагын зорилгын дагуу сайн дурын ажилтнуудыг зохион байгуулах зохицуулагч зайлшгүй шаардлагатай. Сайн дурынхны асуудлыг хариуцсан зохицуулагч ямар ажлыг ямар

сайн дурын ажилтнаар хийлгэхээ мэддэг, сайн дурынхныгаа бүрэн ойлгож, тэдний чадвар дадал, авъяасыг үнэлж мэдэрдэг хүн байх ёстой.

Шинэ Гвиней

Шинэ Гвинейд сайн дурын үйл ажиллагаа гэдэг ухагдахуун нь хүмүүс нэгэн зорилгын дор нэгдэж санаа бодлоо хуваалцах, хоол хүнс, үзэл бодол, хөрөнгө мөнгөөр бусаддаа туслаж тэдний ахуй амьжиргааг дээшлүүлэх утга илэрхийлдэг байна. Жишээлбэл нэгэн бэлэвсэн эхнэр байшин, цэцэрлэгээ засах шаардага гарлаа гэхэд бусад нь очиж түүнд тусладаг гэх мэт. Бусдад туслаж, бусдын төлөө санаа тавих явдал Шинэ Гвинейд "хүсэл зоригийн дагуу" гэж нэрлэгддэг тогтолцоо болсон бөгөөд өөрт байгаа зүйлээ бусадтай хуваалцаж бие биенээ дэмжин туслаж явах нь иргэний үүрэг гэж үздэг байна.

Сайн дурын үйл ажиллагаа олон хэлбэртэй байдаг. Тухайбал нийгмийн ажилтнууд бусаддаа туслаж, сүм хийдийн сайн дурынхан бурханы өмнөөс бусдыг нигүүлсэн ивээн тусладаг гэх мэт. 1990 онд Шинэ Гвинейд Үндэсний сайн дурынхны алба байгуулагдсан бөгөөд үндсэн гурван хөтөлбөрийг хэрэгжүүлдэг ажээ. Үүнд:

- Сайн дурынхныг элсүүлэх хөтөлбөр
- Нийгмийн боловсрол, хөгжлийн хөтөлбөр
- Нийгмийн хамтын ажиллагаа, сан бүрдүүлэх багийн хөтөлбөр

Америк

Европын ихэнх орнуудад засгийн газраас нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлдэг байхад АНУ-д төрийн бус байгууллагууд болон сайн дурын ажилтнууд олон нийтэд нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэхэд онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Энэхүү үйл ажиллагаанд шаардлагатай санхүүгийн эх сурвалжийн ихэнх хувийг хувийн хэвшлийн салбарынхан шийдвэрлэдэг байна. Гэхдээ төрийн бус байгууллагууд болон сайн дурын ажилтнуудын санхүүжилт олох, хөрөнгө мөнгөний сан бүрдүүлэхэд тохиолддог гол бэрхшээл бол:

- Үйл ажиллагааныхаа үр дүнг хандивлагч нартаа үзүүлж харуулах шаардлага тавьдаг
- Төрийн бус байгууллагууд болон хандивлагч нарын дунд бий биендээ итгэх итгэлцэл сул

- Төрийн бус байгууллагууд хандивлагч нартаа хандив өргөсний хариу үнэлэмжийг хэрхэн өгөх
- Төрийн бус байгууллагууд хандив цуглуулж сан бүрдүүлэх хүчин чармайлт сул зэрэг ажээ.

Сан бүрдүүлж хөрөнгө босгох үйл ажиллагаанд дагаж мөрдөх үндсэн журам америкийн сайн дурынхан, төрийн бус байгууллагуудын хувьд дараах байдлаар тодорхойлогддог байна. Үүнд:


- Төрийн бус байгууллагууд нь өөрсдийнхөө бэрхшээлтэй асуудлыг шийдэхээс өмнө хандивлагч нарт учираад байгаа бэрхшээлтэй асуудлыг шийдэх
- Хандивлагч нарт нөлөөлөх өрсөлдөөнт давуу талыг харуулах
- Татгалзсан хариуг хүлээн авч сурах хандивлагч нарынхаа хариуг асуух асуултыг мэддэг, түүнд тохирсон хариултыг өгч чаддаг байх
- Үйл ажиллагаандаа өөрчлөлт хийж, үнийн болоод түүнээс гарах үр дүнг өрсөлдөөнтэй болгох

Ер нь сан бүрдүүлнэ гэдэг бол хөрөнгө мөнгөнөөс гадна өөр бусад бүх зүйлийг агуулж байдаг ухагдахуун билээ. Энэ нь сайн дурын байгууллагуудын мөнхийн үйл ажиллагаа байдаг. Сан бүрдүүлж хөрөнгө босгохдоо дараах хэдэн дүрмийг сайтар мөрдөхийн чухлыг Америкийн нэгэн төрийн бус байгууллагын ажилтан дурджээ. Үүнд:

- Хандив өгөх шалгуур үзүүлэлт, зааварчилгааг хүндэтгэж түүнд нийцсэн хүсэлт тавих бодитой төсөв бүхий санал тавих
- Ил тод байдал
- Санал хүлээн авч буй хандивлагч тухайн материалтай танилцах цаг зав бага гэдгийг анхааран үзэж материалаа оновчтой товч тодорхой бэлтгэх зэрэг болно.

АНУ-д хүмүүс хувь хүнээс илүү хамтлаг бүлгүүдэд хандив өргөх хүсэлтэй байдаг. Америкт сайн дурын ажилтныг хандивлагч гэж үздэг бөгөөд гол ялгаа нь тухайн сайн дурын ажилтан хөрөнгө мөнгөө бус цаг зав, үр чадвараа хандивлаж байгаа хэрэг гэжээ.

Ер нь сайн дурын үйл ажиллагаа тухайн ажилтны анхаарлыг татаж, шинэ үйл ажиллагаанд сургаж байдаг онцлогтой. Сайн дурын ажилтны



хөтөлбөрийн нэг давуу тал нь тухайн ажилтны мэргэжлийн ур чадварыг нь хөгжүүлэх боломжоор хангадаг, бусадтай хамтран ажиллаж, тэднийг удирдаж ажиллах чадвар дадал суулгадаг явдал юм. Хувь хүн сайн дурын ажилтан байж болохоос гадна байгууллага, корпораци сайн дурын дэмжигч байгууллага байж болохыг Америкт үгүйсгэдэггүй бөгөөд энэ нь төрийн бус байгууллагуудын бизнес корпорациудад хандах хандлагыг нааштай болгож байгаа ажээ.

Дэлхийн нийтийн сайн дурын үйл ажиллагаанд эмэгтэй сайн дурынханы гүйцэтгэх үүрэг

Сайн дурын ажилтан, сайн дурын үйл ажиллагаа гэж байгаагүйсэн бол дэлхийн хаана ч эмэгтэйчүүдийн төлөө гэсэн хөдөлгөөн өрнөхгүй байхсан билээ. Иймээс “сайн дурын үйл ажиллагаа гэдэг бол эмэгтэйчүүдийн амьдралын нэгэн салшгүй хэсэг байсаар ирсэн байх ч болно” гэж НҮБ-ийн Сайн дурынхны хөтөлбөрийн



зохицуулагч Шарон Алакижа хэлсэн байна. Дэлхийн зарим орнуудад эмэгтэйчүүд хүнд хэцүү нөхцөлд амьдарч ажиллаж байдаг иймээс сайн дураараа бие биендээ туслахын чухлыг илүү ойлгож энэ эрхэм үйлсэд хүчин зүтгэдэг байж болох юм. Түүнээс гадна сайн дурын үйл ажиллагаанд оролцох нь амжилт олохын нэгэн үндэс байдаг бөгөөд сайн дурынхны жагсаалтанд эмэгтэйчүүд давамгайлдаг ажээ. Сайн дурын үйл ажиллагаанд оролцогч эмэгтэйчүүдийн зарим нь өөрийгөө дутуу үнэлэх явдал байдаг бөгөөд ер нь эмэгтэйчүүдийн үгийн сангаас “Би зөвхөн гэрийн эзэгтэй” гэсэн үгийг авч хаян “Би сайн дурын ажилтан” гэсэн үгийг нэмж оруулах нь чухал гэдгийг сайн дурын байгууллагын ажилтнууд тэмдэглэсэн байна. Эмэгтэй сайн дурынхан эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, эмэгтэйчүүдийн эрх, боловсрол зэрэг салбаруудад илүү чухал үүрэг гүйцэтгэдэг ажээ. Соёл урлагийн салбарт тохиолдож байгаа саад бэрхшээлийг даван туулахдаа эмэгтэйчүүд гарамгай бөгөөд эмэгтэй сайн дурынхан гол тулгуур багана нь болсоор ирсэн байна.

Эмэгтэй сайн дурын ажилтнууд аль ч салбарт ажиллаж амжилт олж чаддаг, гэр бүлийнхээ хүрээнд өөрийн хийж буй үйлийнхээ чухлыг

ойлгуулж чаддаг чадвартай улс байдаг. Тухайлбал: дэлхийд нэртэй эмэгтэй сайн дурын ажилтнууд гэвэл Эланорь Рузвельт, Мари Стопс, Маргарет Санжер, Като нарыг дурьдаж болно. Үнэндээ 1948 оны Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалыг батлан гаргахад Эланорь Рузвельт чармайн хүчин зүтгэсэн байна. Өөрийгөө хөгжүүлж чадсан, бэрхшээлийг ойлгож ухаарсан эмэгтэйчүүд л бусдыгаа зоригжуулан дэмжиж чаддаг.



VI. САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА МОНГОЛД

Монголчууд эртнээс нааш бие биедээ харилцан туслалцаж ирсэн сайхан заншилтай. Сайн дурын үйлс нь бусдын тусын тулд үйлчлэх хүсэл эрмэлзэл бөгөөд эн тэргүүнд бусдын аз жаргал, сайн сайхныг болдох хандлага байдаг. Өөрөөр хэлбэл сайн дураар нэгдэх нь бусдын тусын тулд үйлчлэх хүсэл эрмэлзэл юм.

НҮБ-ын СДБ, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Статистик Мэдээлэл, Судалгааны газар, Монголын Сайн дурынхны нийгэмлэгээс хамтран иргэдийн сайн дурын оролцоо, цаашдын чиг хандлагыг тодорхойлох зорилго бүхий цогц судалгааг Улаанбаатар хотын хэмжээнд 600 хүний дунд өнгөрсөн оны хоёрдугаар улиралд явуулсан байна. Судалгааны дүнгээс үзвэл иргэдийн дундах сайн дурынхны талаарх ойлголт таамаглалд суурилсан ч ерөнхийдөө зөв төсөөлөл ойлголттой байна. Тэрээр сайн дурынхан гэдэг нь бусдын тусын тулд үйлчилдэг хүмүүс, сайхан сэтгэлтэй хүмүүс гэж дийлэнх нь үзсэн байна.

Нийгмийг хөгжүүлэхэд оруулах сайн дурынхны хувь нэмрийг судалгаанд



оролцогсодын дөрвөн хүн тутмын нэг нь сайн мэдэхгүй гэж хариулсан нь хүн амын олонхийг хамарсан сайн дурын үйл ажиллагаа манай оронд өргөн дэлгэр хөгжөөгүйтэй холбоотой. Сайн дурын үйл ажиллагаанд оролцох оролцсоны түвшин, сонирхол хандлага нь хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурь, идэвх оролцоо харьцангуй өндөр, байгууллагуудын хувьд төрийн бус байгууллагууд, буяны болон шашны байгууллагууд идэвхтэй оролцдог байна.

Сайн дурын үйл ажиллагаа нийгмийн аль салбарт чиглэгдэж байгаа тухайд байгаль орчныг хамгаалах салбар, эмзэг бүлгийхэнд туслах, боловсролын системийг хөгжүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалах, ахмад үеийнхнийг халамжлах, эрүүл мэндийг хамгаалах салбарт хувь нэмрээ оруулах сонирхолтой байдаг байна.

Сайн дурын үйл ажиллагаанд оролцох сонирхолын хувьд судалгаанд оролцогчдын 45 хувь нь сайн дурын үйл ажиллагаанд оролцох сонирхолтой, 26 хувь нь урамшуулалтай бол оролцоно гэснээс үзэхэд хүмүүсийн сонирхол их байгаа нь харагдаж байна. Гэтэл судалгаанд сайн дурынхны хэрэгцээ асар их байгаа нь харагдаж байгаа ба өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчдын 93 хувь нь хэрэгцээ зайлшгүй хэрэгтэй, хэрэгтэй гэж үзсэн ба сонирхол хоёрын хоорондхи зөрөө нь урамшилтайгаар ажиллах сонирхол байгааг харуулж байна.



Сайн дурын үйл ажиллагаанд оролцсоны ач тус нь бусадтай туршлага, мэдлэг чадвараа хуваалцах, өөрийгөө хөгжүүлэх, шинэ хүмүүстэй уулзаж танилцахаас гадна өөрийн хийсэн бүтээсний үр дүнг үзэх явдал гэж судалгаанд хамрагдагсад санал нэгтгэйгээр хариулжээ. Ялангуяа залуусын сайн дурын туршлага хуримтлуулж, нийгэмд эзлэх тодорхой байр сууриа олж авах бүрэн боломжтой. Тиймээс сайн дурын үйл ажиллагааны цар хүрээг тэлэн цаашид өргөжүүлэх гол хүчин бол залуус юм. Сайн дурын үйл ажиллагаанд оролцоход учирч буй гол саад бэрхшээл нь хүмүүсийн ажил төрлийн зав чөлөө гардаггүй явдал, нөгөө талаас сайн дурын үйл ажиллагаанд оролцох эсэхээ шийдэж ядсан "эргэлзээ" буюу тэр үеийн байдлаас болно гэсэн хариу харьцангуй их байсан байна.

Сайн дурын үйл ажиллагааг нийтийн үйлс болгохын тулд нэг талаас ухуулга сурталчилгааны ажлыг идэвхжүүлэхийн зэрэгцээ сайн дурын бодит үйл ажиллагаагаар олон түмний сонирхлыг татах аргыг хослуулан хэрэглэх шаардлагатай юм. Сайн дурын үйл ажиллагаа нь улс орны нийгмийн төдийгүй эдийн засгийн амьдралд бий болж хуримтлагдсан оюуны чадавхи, материаллаг үнэт зүйлсийг олон нийтийн идэвхи санаачлага, хүчин чармайлтаар хөдөлгөөнд оруулдгаараа ач холбогдолтой юм.

Сайн дурын байгууллагуудын үйл ажиллагааг төв болон орон нутгийн засаг захиргааны зүгээс онцгой дэмжиж, эрх мэдлийнхээ тодорхой хэсгийг тэдэнд шилжүүлэн, нийгмийн болон эдийн засгийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллах нь нэг талаас сайн дурын байгууллагуудыг бэхжүүлэх, нөгөө талаас төсвийн байгууллагын ачааллыг бууруулах боломж олгох юм.

Монголын Сайн Дурынхны Нийгэмлэг

Монголын Сайн Дурынхны Нийгэмлэг 1998 оны 10 сарын 31-ний өдөр байгуулагдсан. Тус нийгэмлэг нь нийгмийн сайн сайхны үйлст өөрийн хувь нэмрийг оруулах хүсэлтэй ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг сайн дурын үндсэн дээр нэгтгэсэн, ашгийн төлөө бус, олон нийтийн байгууллага юм.

- Монголын Улаан Загалмайн Нийгэмлэг

Монголын Улаан Загалмайн Нийгэмлэг нь 1939 онд байгуурлагджээ. МУЗН-ийн гол зорилго нь Олон улсын Улаан Загалмайн болон Улаан Хавирган Сар хөдөлгөөний үйл ажиллагаа, үндсэн зарчим болоод ач холбогдлыг олон нийтэд таниулах, Улаан Загалмайн нийгэмд гүйцэтгэх үүргийг батжуулах болон олон нийтийн хүчийг аливаа хүмүүнлэгийн зорилгод нэгтгэхэд оршиж байна. Хүн бүр ямарваа гарал үүсэл, үндэсний харьяалал, арьс өнгө, нас хүйс, шашин шүтлэг болон улс төрийн үзэл бодол ялгалгүй нийгэмлэгийн гишүүнчлэлд хамрагдаж болдог.

ТӨЛӨВ

Ашигласан материал:

- Интернет
- Монголын СДН-ээс явуулсан судалгаа
- НҮБ-ын СДБ-аас гаргасан "Сайн дурын үйл ажиллагаа Монголд" товхимол

